| D3. REDD+-ийнБАХ-нүүдийг төлөвлөж, хэрэгжүүлэхдээ холбогдох үндэсний хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдтэй уялдуулсан байх ба салбар дундын болон олон талын хамтын ажиллагааны механизмуудыг ашиглан REDD+ БАХ-нүүдийг хэрэгжүүлж хяналт тавина. | **Тусгах:**<br>D3.1. REDD+-тэй холбоотой хөгжлийн бодлого, хөтөлбөрүүд болон тэдгээрт тусгагдсан оролцогч талуудын оролцоог хангах, хамтын ажиллагааг зохицуулсан механизм/платформуудын талаарх мэдээлэл. | • Улс болон аймгийн түвшинд REDD+ арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхтэй холбоотой гол хөгжлийн бодлого, хөтөлбөр, механизмуудын жагсаалт (жишээ нь ҮХГ, ҮХН платформ, иргэдийн хурал г.м.) (СНСЗ В-тэй давхцана)<br>• Тэдгээр заалт, механизмуудыг REDD+Үндэсний хөтөлбөр хэрхэн тусгагдсан болохыг тайлбарлах (СНСЗ В-тэй давхцана). |
| | **Хэрэгжүүлэх:**<br>D3.2. REDD+ арга хэмжээний хүрээнд олон салбарууд ба талуудын оролцоог хангахад дээрх платформ/механизмуудыг хэрхэн ашиглаж буй талаарх мэдээлэл. | • Механизм/платформуудын ашиглалттай холбогдсон баримт баталгаа, үр дүн. Үүнд:<br>- ҮХГ-аас явуулсан REDD+Үндэсний хөтөлбөр ийн үнэлгээ ба ҮХГ-ын мэдээллийн санд оруулсан мэдээлэл<br>- ҮХГ-ын платформд оролцсон байдал<br>- Иргэдийн хурлын үйл явц<br>- Нийгэм-эдийн засгийн хөгжлийн хөтөлбөрүүдтэй уялдсан байдал<br>- REDD+-ийн БАХ болон холбогдох бусад арга хэмжээнд оролцсон өөр өөр салбарын төлөөллүүдийн талаарх тоо баримт |

<table>
<tr><td rowspan="2">D4. МУ-ын Засгийн газар нь REDD+ийн бодлого, арга хэмжээний хэрэгжилтийн улмаас эрх нь зөрчигдсөн гэх иргэд болон талуудад холбогдох БХЖ-ын дагуу санал гомдлоо шийдвэрлүүлэх эрхийг нь хангаж,  гомдол, санал барагдуулах зохистой, ил тод механизмыг бүрдүүлж өгсөн байна.</td><td>Тусгах:<br><br>D4.1. REDD+ явцтай холбоотойгоор  зөрчил үүссэн үед иргэд болон холбогдох оролцогч талууд гомдлоо зохих ёсоор шийдвэрлүүлэх эрхтэй байхыг хуульчилсан БХЖ, механизмуудын талаар мэдээлэл.<br><br>D4.2. Тэдгээр заалтуудыг REDD+Үндэсний хөтөлбөр болон эсвэл REDD+ үйл ажиллагаанд хэрхэн тусгасан талаарх /тухайлбал санал гомдол хүлээж авах зохих ёсны ил тод механизмаар дамжуулж шийдвэрлэдэг байх г.м/</td><td>• REDD+ -ийн үйл ажиллагааны хүрээнд үүсэх санал гомдлыг зохих ёсоор шийдвэрлэхтэй холбоотой БХЖ-ын заалт, механизмуудын жагсаалт (Жишээ нь Хүний эрхийн үндэсний комиссын шийдвэр, Захиргааны ерөнхий хууль г.м.)<br>• Тэдгээр заалт, механизмууд REDD+Үндэсний  хөтөлбөрт хэрхэн тусгагдсан болохыг тайлбарлах (жишээ нь, ГМБ-ыг ашиглах г.м)</td></tr>
<tr><td>Хэрэгжүүлэх:<br><br>D4.3. Иргэд болон холбогдох оролцогч талуудын санал гомдлоо зохих ёсоор шийдвэрлүүлэх эрхийг хангах, санал сэтгэгдэл хүлээн авах механизмыг хуульчилсан холбогдох заалтуудын хэрэгжилтийн мэдээлэл .</td><td>• Тэдгээр заалт, механизмуудыг хэрэгжүүлсэн үр дүнгийн тоо баримт, жишээ нь:<br>- Шийдвэрлэсэн санал гомдлын тоо (үүнийг дотор нь ангилсан байдлаар, жишээ нь газартай холбоотой, үр ашигтай холбоотой г.м)<br>- Санал, гомдлуудыг аймаг тус бүрээр нэгтгэсэн мэдээлэл<br>- Санал гомдлуудыг оролцогч талуудын бүлгээр хуваасан байдал (жендерээр г.м.)<br><br>(тайлбар: ашигласан арга барилаас хамааран эдгээр тоо баримтыг REDD+-ийн тодорхой арга хэмжээний хүрээнд бүрдүүлэх ба зарим тохиолдолд  тэдгээр тоо, мэдээллийг одоогийн механизмуудаар дамжуулж цуглуулж болно.)</td></tr>
</table>

| СНСЗ Е: Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчим Е: Тэдгээр үйл ажиллагаа нь байгалийн ой, биологийн олон янз байдлыг хамгаалах асуудалтай нийцсэн байх ба [REDD+] үйл ажиллагааг байгалийн ойг хувиргахад ашиглах бус харин байгалийн ой болон түүнийг экосистемийн үйлчилгээг хамгаалахад чиглэсэн урамшуулал бий болгох, мөн нийгэм, байгаль орчны бусад үр ашгийг сайжруулахад ашигладаг байх. | | |
|---|---|---|
| **Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмыг үндэсний нөхцөлд элемент бүрээр тодорхойлсон нь** | **Мэдээллийн хэрэгцээ** | **Шалгуур үзүүлэлтийн агуулга, үндэслэл** |
| E1. REDD+ БАХ-нүүд нь байгалийн ойн талаарх улсын хэмжээнд мөрдөж байгаа албан ёсны тодорхойлолтод суурилсан, түүнд нийцсэн байна. | **Тусгах:**<br>E1.1. Байгалийн ойн талаарх улсын хэмжээнд мөрдөж байгаа албан ёсны тодорхойлолт<br>E1.2. Дээрх тодорхойлолт нь REDD+Үндэсний хөтөлбөр болон REDD+-ийн гол баримт бичгүүдэд хэрхэн тусгагдсан талаарх мэдээлэл. | • Улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, ойн тодорхойлолт. Боломжтой бол байгалийн ойн талаарх ойлголт, тодорхойлол нь холбогдох эрх зүйн баримт бичгүүдэд хэр жигд тусгагдсан талаар тайлбарлана.<br>• Ой болон байгалийн ойн тодорхойлолт REDD+Үндэсний хөтөлбөр болон үндсэн баримт бичгүүдэд (ОСТ, ҮОМС) хэрхэн тусгагдсаныг тайлбарлах. |
| | **Хэрэгжүүлэх:**<br>E1.2. Дээрх тодорхойлолт нь REDD+Үндэсний хөтөлбөр болон REDD+-ийн гол баримт бичгүүдэд хэрхэн тусгагдсан талаарх мэдээлэл. | • Ой болон байгалийн ойн тодорхойлолт REDD+Үндэсний хөтөлбөр болон үндсэн баримт бичгүүдэд (ОСТ, ҮОМС) хэрхэн тусгагдсаныг тайлбарлах. |
| E2. REDD+ БАХ-нүүдийг боловсруулж, хэрэгжүүлэхдээ ойн сан бүхий болон ойгоос бусад газар нутгийн аль алинд нь учрах нөлөөллийг үнэлэхтэй холбоотой хууль эрх зүйн шаардлагыг бүрэн хангасан байна. | **Тусгах:**<br>E2.1. REDD+ -ийн нөлөөллийн үнэлгээний талаар зохицуулсан БХЖ-уудын мэдээлэл<br>E2.2 Дээрх заалтуудыг REDD+Үндэсний хөтөлбөр болон REDD+-ийн гол баримт бичгүүдэд хэрхэн тусгасныг тайлбарлах. | • Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай холбогдох зүйл заалтуудыг тайлбарлах (жишээ нь БОНБҮТХ, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль г.м)<br>• Дээрх зүйл заалтууд REDD+ арга хэмжээний хүрээнд хэрхэн хамаарч буй талаар мөн бусад баримт бичгүүдэд (жишээ нь |

| | | |
|---|---|---|
| | | REDD+Үндэсний хөтөлбөрийн төсөл, санал солилцох үйл явцад г.м) хэрхэн хэрэглэгдэж, тусгагдсаныг тайлбарлах үүний дотор ой болон ойгүй газруудыг авч үзэх (бэлчээрийн болон хадлангийн зориулалтаар ашиглах газар г.м орно) |
| | **Хэрэгжүүлэх:**<br>E2.2. Нөлөөллийн үнэлгээтэй холбогдолтой зүйл, заалтууд улсын хэмжээнд хэрхэн хэрэгжиж байгаа талаарх мэдээлэл.<br>E2.3. REDD+-ийн хүрээнд нөлөөллийг үнэлэх үйл ажиллагаа хэрхэн хэрэгжиж байгаа талаарх мэдээлэл. | • Улсын хэмжээнд (боломжтой бол мөн аймгийн хэмжээнд) байгаль орчны нөлөөллийн үнэлгээний хэрэгжилт ямар байгаа талаарх тоо баримт, жишээ нь:<br>- ҮХГ-ын мэдээллийн сан дах үнэлгээ хийгдсэн хөтөлбөр, бодлогын тоо<br>- Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний мэдээллийн сан дах батлагдсан байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тоо (салбараар)<br>• REDD+-ийн хүрээнд хэрэгжүүлсэн нөлөөллийн үнэлгээний арга хэмжээний тайлбар ба үр дүн, жишээ нь:<br>- Улсын хэмжээнд REDD+Үндэсний хөтөлбөрийн хүрээнд үүсч болох үр ашиг, эрсдэлийг үнэлэх, тус хөтөлбөрийн бодлогын нөлөөллийн үнэлгээ (үүний дотор ойн болон ойгүй газар нутгийн нөлөөллийг тусгайлан дурдах )<br>-дэд хөтөлбөр болон аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх үйл |

| | | |
|---|---|---|
| | | ажиллагааны үр ашиг, эрсдэлийн талаарх хэлэлцүүлэг<br>- REDD+ БАХ-ний хүрээнд хэрэгжүүлсэн аливаа нөлөөллийн үнэлгээний арга хэмжээ (шаардлагатай бол) |
| E3. REDD+ БАХ-нүүд нь байгалийн ойг хамгаалах, хадгалах явдлыг урамшуулах, ой ашиглагчдын хариуцлагыг дэмжихэд чиглэсэн арга хэмжээнүүдийг илүү сонгон хэрэгжүүлж, байгалийн ойг доройтуулахаас зайлсхийх буюу эрсдэлийг бууруулна. | **Тусгах:**<br>E3.1. REDD+ арга хэмжээний хүрээнд хамаарах ой хамгааллын асуудлыг тусгасан БХЖ-ууд болон ойн хамгаалал, тогтвортой хэрэглээ ба хариуцлагын тогтолцоог сайжруулахад чиглэсэн урамшууллын (санхүүгийн болон санхүүгийн бус) тухай мэдээлэл<br>E3.2. Үндэсний REDD+ хөтөлбөр, үүний дотор ой хамгаалал, урамшуулал, тогтвортой ашиглалт ба хариуцлагын тогтолцоог дэмжихэд чиглэсэн тодорхой БАХ-нүүдийн талаарх мэдээлэл. | • Ойн хамгаалал, урамшуулал ба хариуцлагын тогтолцоог сайжруулахад чиглэсэн холбогдох зүйл заалтыг тайлбарлах (жишээ нь Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль, Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр, Ойн тухай хууль, хууль бус мод бэлтгэлийг мэдээлэхэд олгох урамшуулал г.м.)<br>• Үндэсний REDD+ хөтөлбөрт тусгагдсан ой хамгаалал, урамшуулалтай холбоотой тодорхой үйл явц болон БАХ-үүдийн талаарх мэдээлэл, жишээ нь:<br>- Байгалийн ойг хамгаалах, байгалийн нөөцийг хамгаалагч иргэд болон ашиглагчдыг чадавхжуулахад чиглэсэн БАХ-нүүд<br>- Хамгаалалтад авах, хамгаалалтын үр өгөөжийг бий болгох газар нутгийг эрэмбэлэх үйл явц<br>- Үр ашиг, урамшуулал хуваарилах механизм (СНСЗ B-тэй давхацна) |

| | | |
|---|---|---|
| | **Хэрэгжүүлэх:**<br>Е3.3. Үндэсний хэмжээнд REDD+-ийн хүрээнд хэрэгжүүлж байгаа ойн хамгаалах үйл ажиллагаа, ойн хамгаалал, тогтвортой ашиглалтыг дэмжих урамшууллын талаарх мэдээлэл<br>Е3.4. REDD+Үндэсний хөтөлбөрийн хүрээнд тусгагдсан ой хамгаалах үйл ажиллагаа, ой хамгаалал болон тогтвортой ашиглалтыг дэмжих урамшуулалтай холбоотой БАХ-нүүдийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл | • Тодорхойлсон зүйл, заалтуудыг хэрэгжүүлж буй тоо баримт, жишээ нь:<br>- Тодорхой хөтөлбөрүүдийн санхүүжилт (шилэн данснаас)<br>- Зорилтуудын биелэлт , ж.нь ТХГН-ийн сүлжээ г.м<br>- “Урамшуулал олгох” журмыг хэрэгжүүлсэн талаарх тоо баримт (хүлээж авсан мэдээлэл, олгосон урамшуулал г.м)<br>• Улсын болон аймгийн түвшин дэх байгалийн ойн бүрхэвч ба ойн төлөв байдлын талаарх  тоо баримт (эсвэл боломжтой бол REDD+ арга хэмжээг хэрэгжүүлж буй газар нутгаар нь гаргах, жишээ нь:<br>- Байгалийн ойн бүрхэвчийн хэмжээ хязгаар, статус ба цагийн явцад хувьссан байдал (ойн мэдээллийн сан, ҮОМС)<br>- Байгалийн ойн бүрхэвчийн чанар (ургах нягтрал), статус ба цагийн явцад өөрчлөгдөж хувьссан байдал<br>• Тодорхой БАХ-ний хэрэгжилтийн үр дүнгийн мэдээлэл, тоо баримт, жишээ нь:<br>- Орон нутагт байгаль хамгаалах чиглэлээр байгуулагдсан холбоодын тоо<br>- Байгалийн баялгийг хамгаалж тогтвортой ашиглах эрх олгогдсон нөхөрлөлийн тоо (бусад бүлэг, аж ахуйн нэгжүүд) |

| | | |
|---|---|---|
| | | - Түймрээс сэргийлэх, хянахтай холбоотой үр дүн<br>- Эргүүл хийх үйл ажиллагаа нэмэгдсэн үр дүн<br>• Үр ашиг, урамшуулал хуваарилсан тоо баримт (мөнгөн болон мөнгөн бус) (СНС3 В-тэй давхцана), жишээ нь:<br>- Санхүүгийн урамшуулал, үр ашиг хуваарилсантай холбоотой тоо баримт<br>- Сургалт ба чадавх бэхжүүлэх үйл ажиллагааны тоо<br>- Ой болон байгалийн нөөцийг ашиглах боломж сайжирсан талаарх мэдээлэл<br>- Үр ашиг, урамшуулал хуваарилахтай холбоотой гомдол (D4-тэй давхацна) |
| E4. REDD+-ийнүйл ажиллагааг байгалийн ойг таримал ой болгон хувиргах буюу бусад зориулалтаар өөрчлөхөд ашиглахгүй, ийнхүү хувиргахыг дэмжихгүй байх | **Тусгах:**<br>E4.1. Монгол орны нөхцөлд REDD+ арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх хүрээнд байгалийн ойг хувиргах асуудлыг зохицуулсан бодлого, хууль журмын талаарх мэдээлэл<br>E4.2. REDD+ арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх явцад үүсч болох байгалийн ой хувирах эрсдэлийг тодорхойлсон тухай мэдээлэл | • Байгалийн ойг хувиргах болон эс хувиргахтай холбоотой аливаа зүйл, заалтыг тайлбарлах (жишээ нь, Ойн тухай хууль, ойн суурь түвшин)<br>• Үр ашиг ба эрсдэлийн үнэлгээнд тодорхойлогдсон, байгалийн ойг хувиргахтай холбоотой аливаа эрсдэл болон тэрхүү эрсдэлээс зайлсхийх, бууруулах арга хэмжээний талаарх тайлбар (боломжтой бол дээрх арга хэмжээг REDD+Үндэсний хөтөлбөр, БАХ-д хэрхэн тусгасан талаар тайлбарлах) |

| | | |
|---|---|---|
| | **Хэрэгжүүлэх:**<br>E4.3. Байгалийн ой хувирах эрсдэлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл<br>E4.4. REDD+ арга хэмжээ хэрэгжиж буй бүс нутагт болон улсын хэмжээнд байгалийн ойн бүрхэвч болон чанартай холбоотой гарч байгаа үр дүн. | • Эрсдэл бууруулах арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн үр дүнгийн тоо баримт ба тайлбар.<br>• Улсын болон аймгуудын хэмжээнд гарч байгаа байгалийн ойн бүрхэвч ба төлөв байдалтай холбоотой үр дүнг илтгэх тоо баримт (эсвэл мэдээлэл байвал REDD+ үйл ажиллагаа хэрэгжиж буй газар нутгаар нь мэдээллийг бүрдүүлэх) (E3 дахь байгалийн ойн бүрхэвч, чанарын үзүүлэлттэй ижил)). |
| E5. REDD+-ийн үйл ажиллагааг боловсруулах, эрэмбэлж, хэрэгжүүлэхдээ нийгмийн сөрөг нөлөө учруулахаас зайлсхийж, эдийн засаг, нийгмийн сайн сайхан байдал, үр ашгийг дэмжиж, ялангуяа эмзэг бүлгийн хүмүүст ажил эрхлэх боломжийг нь нэмэгдүүлэх талаар онцгой анхаарал хандуулна. | **Тусгах:**<br>E5.1. Монгол оронд REDD+-ийг хэрэгжүүлэх хүрээнд нийгэм эдийн засгийн үр ашгийг дэмжих ба нийгэм эдийн засгийн сөрөг нөлөөллийг бууруулахтай холбоотой аливаа бодлого, хууль, журмын талаарх мэдээлэл<br>E5.2. Гарч болох нийгэм-эдийн засгийн үр ашиг ба эрсдэл, ялангуяа хөдөлмөр эрхлэлттэй холбоотой үр ашиг ба эрсдэлийг хэрхэн тодорхойлсон болоод тэдгээрийг Үндэсний REDD+ хөтөлбөрт хэрхэн тусгасан талаарх мэдээлэл | • Нийгэм-эдийн засгийн үр ашиг, нөлөөтэй хамааралтай холбогдох заалтуудыг тайлбарлах (жишээ нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Төрөөс ойн талаар баримтлах бодлого гэх мэт)<br>• Эмзэг бүлгүүдийн тодорхойлолт (Оролцогч талуудтай холбоотой СНСЗ D-тэй холбоотой)<br>• Үр ашиг ба эрсдэлийн үнэлгээний явцад тодорхойлогдсон нийгэм эдийн засгийн үр ашиг ба эрсдэлүүд болон үр ашгийг дээшлүүлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний талаарх тайлбар (боломжтой бол тэдгээр арга хэмжээг REDD+ Үндэсний хөтөлбөр, БАХ-нүүдэд хэрхэн тусгасан талаар тайлбарлах) мөн эдгээр нь холбогдох БХЖ-уудтай хэрхэн уялдаж байгаа талаарх тайлбар |

| | | |
|---|---|---|
| | **Хэрэгжүүлэх:**<br>E5.2. REDD+Үндэсний  хөтөлбөр нь нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөллийг хэрхэн бууруулж, эдийн засгийн болон нийгмийн сайн сайхан байдлыг хэрхэн дээшлүүлж байгаа талаарх мэдээлэл | • REDD+ -тэй холбоотой, үндэсний болон аймгийн түвшний нийгэм-эдийн засгийн чиг хандлагын талаарх статистик, жишээ нь:<br>- Ойн салбар дахь ажил эрхлэлт<br>- Ойн салбарын орлогын эх үүсвэр<br>- Мод бэлтгэл, ойн дагалт баялаг боловсруулах бизнес<br>- Ойд суурилсан аялал жуулчлал, амралт зугаалгын газар нутаг (хэрэв мэдээлэл байгаа бол ҮСХ-ноос аялал жуулчлалын салбарын мэдээллийг байршил, чиглэлээр нь ангилж гаргасан мэдээлэл авах)<br>- Ойн нөхөрлөл болон бусад бүлгүүдэд үзүүлж буй дэмжлэг ( СНСЗ B-тэй давхацна)<br>- Урамшуулал (E3-тай давхацна)<br>• REDD+-ийн тодорхойлогдсон үр ашиг, эрсдэлүүд болон үр ашгийг дээшлүүлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний хүрээнд гарсан үр дүнгийн тоо баримт, ялангуяа эмзэг бүлгийнхэнд нааштай үр дүн гарсан талаарх мэдээлэл.  Үүнд:<br>-  REDD+ -ийн үйл ажиллагааны хүрээнд бий болсон эдийн засгийн үр ашиг (СНСЗ B-тэй давхацна)<br>-  Ойн салбарт оруулсан хувь нэмэр<br>- REDD+ -ийн арга хэмжээний хүрээнд ойн баялгийн хүртээмж дээшилсэн тухай баримт (жишээ нь ойн дагалт баялаг болон ойн нөхөрлөлтэй холбоотой БАХ-үүд) |

| | | |
|---|---|---|
| | | - REDD+Үндэсний  хөтөлбөр , REDD+-ийн БАХ-ний хүрээнд зохион байгуулсан сургалт, чадавх сайжруулах арга хэмжээ<br>- Нийгэм-эдийн засгийн үр нөлөө, ажил эрхлэлттэй холбоотой санал гомдлын тоо баримт (D4-тэй давхацна) |
| E6. REDD+ БАХ-нүүд оролцогч талуудтай орон нутгийн болон үндэсний хэмжээнд зөвлөлдсөний үндсэн дээр хамгаалалтын ач холбогдол өндөртэй ойг тодорхойлж, тэдгээрийн экосистемийн үйлчилгээг хамгаалах, нөхөн сэргээхэд тусална. | **Тусгах:**<br>E6.1. REDD+-ийн хүрээнд экосистемийн үйлчилгээг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбогдолтой бодлого, хууль, журмын талаарх тайлбар<br>E6.2. Үндэсний REDD+ хөтөлбөр нь хамгаалалтын ач холбогдол өндөртэй экосистемийг хамгаалах, нөхөн сэргээх арга арга хэмжээг хэрхэн  тусгасан талаар, ялангуяа үүнтэй холбоотой зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлэг хийсэн эсэх талаарх мэдээлэл | • Хамгаалалтын ач холбогдол өндөртэй экосистемийг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой бодлого, хууль, журмыг тайлбарлах (Төрөөс ойн талаар баримтлах бодлого, Биологийн олон янз байдлын тухай үндэсний хөтөлбөр, Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль г.м.), хамгийн ач холбогдол өндөртэй экосистемүүдийн жагсаалт<br>• Тэдгээр зүйл, заалтууд Үндэсний REDD+ хөтөлбөрт хэрхэн тусгагдсаныг тайлбарлах, үүнд:<br>- Экосистемийн үйлчилгээнд хамаарах үр ашиг ба эрсдэлүүд болон тэдгээрийг сайжруулах/эрсдэлийг бууруулах арга хэмжээ<br>- Газар нутаг, экосистемийн үйлчилгээг ач холбогдлоор нь эрэмбэлэхдээ холбогдох талуудтай зөвлөлдсөн эсэх талаарх мэдээлэл (жишээ нь дэд хөтөлбөр) |

| | | |
|---|---|---|
| | | - REDD+ Үндэсний хөтөлбөрт аль нэг хамгаалалтын ач холбогдол өндөртэй экосистемийн үйлчилгээ болон газар нутгийг сонгож, голлон анхаарсан эсэх (заган ой г.м.)<br>- Хамгаалалтын ач холбогдол өндөртэй экосистемийн үйлчилгээг хамгаалах, нөхөн сэргээхэд чиглэгдсэн БАХ-үүд байгаа эсэх (усны эх үүсвэрийг хамгаалах, заган ойг нөхөн сэргээх г.м.) |
| | **Хэрэгжүүлэх:**<br>Е6.3. Улс, аймгийн хэмжээнд хамгаалалтын ач холбогдол өндөртэй экосистемийн үйлчилгээг хамгаалж, нөхөн сэргээх чиглэлээр гарсан үр дүн.<br>Е6.4. REDD+ Үндэсний хөтөлбөр нь хамгаалалтын ач холбогдол өндөртэй экосистемийн үйлчилгээг хамгаалж, нөхөн сэргээхийг хэрхэн дэмжиж байгаа талаарх мэдээлэл. | • Хамгаалалтын ач холбогдол өндөртэй экосистемийн үйлчилгээнээс хамааран улс болон эсвэл аймгийн түвшинд гарч байгаа тоо баримт, статистикийн мэдээг бүрдүүлнэ. Үүнд:<br>- Ойн экосистемийн үйлчилгээ (ойн дагалт баялаг, түлээний мод, огтолсон мод – СНСЗ Е5.2-той давхацна)<br>- Тусгай хамгаалалттай газар нутгийн систем (хамгаалалттай газар нутаг, нөхөн сэргээсэн нутаг)<br>- Гидрологийн экосистемийн үйлчилгээ (хамгаалалтад байгаа болон нөхөн сэргээгдсэн намаг, усны нөөцийн мэдээлэл г.м.)<br>- Доройтсон газар бүхий нутаг дэвсгэр, доройтолд өртсөн, нөхөн сэргээсэн нутаг дэвсгэр<br>- Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад оруулах үндэсний |

| | | |
|---|---|---|
| | | хувь нэмэр, цаг уурын өөрчлөлтийн зорилттой харьцуулах чиг хандлагууд<br>• Тодорхойлсон БАХ-нүүдэд хамаарах үр дүн, экосистемийн үйлчилгээг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой үр ашиг, эрсдэл, түүнчлэн үр ашгийг дээшлүүлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээтэй холбоотой тоо баримт, үүнд:<br>- Ойн хамгаалал болон нөхөн сэргээлтийн зорилтуудад REDD+-ийн оруулах хувь нэмэр (боломжтой бол YOMC-ээс)<br>- Ойн экосистемийн үйлчилгээнд хамааралтай БАХ -нүүд (түлээний мод, ойн дагалт баялаг г.м.)<br>- Тусгай хамгаалалттай газар нутагтай холбоотой БАХ-үүд, арга хэмжээний үр дүн (олон нийтийн байгаль хамгаалах холбоо хамгааллын хамтын нэгдэл г.м)<br>- Усны нөөцтэй холбоотой БАХ-үүд, арга хэмжээний үр дүн (жишээ нь усны эх үүсвэрийг хамгаалах)<br>- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадварыг сайжруулахтай холбоотой БАХ-үүд, арга хэмжээний үр дүн |

| **Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчим F: Үр дүн хувирах эрсдэлийг тооцох** | | |
|---|---|---|
| **Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмыг үндэсний нөхцөлд элемент бүрээр тодорхойлсон нь** | **Мэдээллийн хэрэгцээ** | **Шалгуур үзүүлэлтийн агуулга, үндэслэл** |
| F1. REDD+-ийн үйл ажиллагааг төлөвлөх, сонгох болон хэрэгжүүлж, хяналт тавихдаа ойн хомсдол, доройтолд хүргэж буй голлох шууд болон дам хүчин зүйлсийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаануудыг хамруулахын зэрэгцээ REDD+ арга хэмжээнүүдийг Монгол Улсад тогтвортой хэрэгжүүлэхэд гол тулгуур болох ойн тогтвортой менежмент, хамгааллын үйл ажиллагааг орон нутгийн болон улсын хэмжээнд сайжруулахад саад болж буй бэрхшээлийг шийдвэрлэх арга хэмжээнүүдийг ойн салбарын холбогдох БХЖ-ын дагуу тусгасан байна. | **Тусгах:**<br>F1.1. Ойн хомсдол, доройтолд хүргэж буй голлох шууд болон дам хүчин зүйлсийг REDD+-ийн БАХ-г улсын хэмжээнд боловсруулах явцад тодорхойлсон тухай, мөн тэдгээрийг БАХ боловсруулах ажилд хэрхэн тусгасан талаарх мэдээлэх<br><br>F1.2. REDD+-ийн Хяналт, үнэлгээний систем нь ойн хомсдол, доройтолд хүргэж буй голлох шууд болон дам хүчин зүйлсийг бууруулахад REDD+-ийн зүгээс үзүүлж буй нөлөөллийг хэрхэн хянаж байгаа талаарх мэдээлэл | • Үндэсний хэмжээнд БАХ-нүүдийг төлөвлөх, REDD+Үндэсний хөтөлбөрийг боловсруулах талаар хэрэгжүүлсэн үйл явцуудын тухай (орон нутгийн түвшинд дэд хөтөлбөрийг боловсруулсан тухай) тайлбар:<br>- ойн хомсдол, доройтолд хүргэж буй голлох шууд болон дам хүчин зүйлсийн дүн шинжилгээ<br>- БАХ-ний төлөвлөлт, энэ нь ойн хомсдол, доройтолд хүргэж буй голлох шууд болон дам хүчин зүйлстэй хэрхэн холбогдож байгаа талаарх мэдээлэл<br>- Үр ашиг ба эрсдэлийн үнэлгээ (удаан хугацааны тогтвортой байдалд хамаарна)<br>• БАХ-нүүд нь шууд болон дам хүчин зүйлсийг хэрхэн бууруулж байгаа талаар, мөн тодорхой хүчин зүйлийг бууруулахад чиглэсэн БАХ-ний талаарх тайлбар<br>• REDD+-ийн Хяналт, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдээр дамжуулж ойн хомсдол, доройтолд хүргэж буй голлох шууд болон дам хүчин зүйлсийг бууруулахад REDD+-ийн |

| | | |
|---|---|---|
| | | зүгээс үзүүлж буй нөлөөллийг хэрхэн хянах талаарх мэдээлэл<br>• Холбогдох шалгуур үзүүлэлтүүд, |
| | **Хэрэгжүүлэх:**<br>F1.3. REDD+-ийн мониторингийн системээр дамжуулан ойн хомсдол, доройтолд хүргэж буй голлох шууд болон дам хүчин зүйлсийг бууруулах чиглэлээр гарч байгаа үр дүнг хянаж байгаа талаарх мэдээлэл. | • Тайлангийн хугацаанд хяналт, үнэлгээг хэрхэн хэрэгжүүлснийг тайлбарлах, жишээ нь давтамж, ямар агентлагаар г.м.<br>• Ойн хомсдол, доройтолд хүргэж буй голлох шууд болон дам хүчин зүйлсийг бууруулахад REDD+-ийн үзүүлж буй нөлөөтэй холбоотой тоо, баримт (дээр дурдсан холбогдох үзүүлэлтүүд ба БАХ дээр үндэслэсэн байна)-ыг бүрдүүлэх |
| F2. REDD+ БАХ-нүүдийг боловсруулж, хэрэгжүүлэхдээ үр дүн хувирч, эсрэгээр өөрчлөгдөж болох эрсдэлүүдийг харгалзаж үзсэн байна. Эдгээр эрсдэлд (хуулийн, нийгэм, экологийн хүчин зүйлс буюу бодлого өөрчлөгдөж, ойн нөөцийн хэт ашиглалт нэмэгдэх г.м) дүн шинжилгээ хийсний үндсэн дээр, REDD+ БАХ-нүүдийг боловсруулж, хэрэгжүүлэхдээ үр дүн хувирах эрсдэлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг тусгасан байна. | **Тусгах:**<br>F2.1. Үр дүн хувирах эрсдэлийг (үүний дотор эрх зүй, нийгэм, экологийн хүчин зүйлүүд) хэрхэн тодорхойлж REDD+Үндэсний хөтөлбөр боловсруулах явцад хэрхэн тусгасан талаарх мэдээлэл.<br>F2.2. Үр дүн хувирах эрсдэлийг бууруулахад чиглэсэн тусгай бодлого, арга хэмжээнүүдийг тодорхойлж, REDD+ Үндэсний хөтөлбөр болон БАХ-нүүдэд тусгагдсан талаарх мэдээлэл | • REDD+-ийн эрсдэл ба үр ашгийг улсын болон аймгийн хэмжээнд үнэлсэн талаарх мэдээлэл<br>• Үр дүн хувирахтай холбоотой эрсдэлүүдийн хураангуй<br>• Үр дүн хувирах эрсдэлийн эсрэг арга хэмжээ авахад дэмжлэг үзүүлэх БАХ-ний тайлбар |
| | **Хэрэгжүүлэх:**<br>F2.3. Үр дүн хувирах эрсдэлээс зайлсхийх, бууруулах чиглэлээр тодорхойлсон хэмжээнүүдийн хэрэгжилттэй холбогдолтой мэдээлэл. | • Дээр тодорхойлсон БАХ ба үр дүн хувирах эрсдэлийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн үр дүн, тоо баримт, үүнд:<br>- Суурь далд хүчин зүйлсийг бууруулах БАХ-нүүд |

| | | |
|---|---|---|
| | | - REDD+-ийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээнүүд |
| F3. Үндэсний ойн мониторингийн систем (ҮОМС)-ийг боловсруулж, сайжруулан ашиглахдаа хөтөлбөрийн үр дүн хувирч, өөрчлөгдөж байгаа талаар болон өмнө тодорхойлсон эрсдэлүүдтэй холбоотой мэдээллийг илрүүлэх давтамж, тохиргоог хийж өгсөн байна. Үүнийг хэрэгжүүлэх хүний нөөцийн болон техникийн чадавхыг бүрдүүлсэн байна. | **Тусгах:**<br>F3.1. ҮОМС-д үр дүн хувирч байгаа эрсдэлүүдтэй холбоотой мэдээллийг илрүүлэх, үүний дотор үр дүн хувирах эрсдэлийн тодорхойлолт, ийм эрсдэл үүссэн үед авах арга хэмжээтэй холбоотой мэдээллийг бүрдүүлж байх тохиргоог хэрхэн хийсэн тухай тухай мэдээлэл<br>F3.2 ҮОМС-д хуваарилсан боловсон хүчин, техникийн нөөцийн хүрэлцээний талаарх мэдээлэл. | • ҮОМС-ийн бүтцийн тайлбар, үүнд:<br>- Үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд<br>- Оролцож ажиллах байгууллагууд<br>- Дүн шинжилгээний төрөл ба тайлангийн давтамж<br>• Монгол улсад хэрэглэгдэж байгаа “үр дүн хувирах” гэсэн ойлголтын тодорхойлолтыг тайлбарлах<br>• ҮОМС-д оноосон нөөцийн тухай тайлбар: боловсон хүчин, техник тоног төхөөрөмж, чадавх дээшлүүлэх болон уг системийг ажиллуулахтай холбоотой санхүүжилт г.м |
| | **Хэрэгжүүлэх:**<br>F3.3. Үндэсний ойн мониторингийн систем (ҮОМС)-ийн хэрэгжилттэй холбоотой мэдээлэл, үүний дотор ашигласан боловсон хүчин болон техникийн нөөц.<br>F3.3. Үр дүн хувирсан байж болзошгүй тохиолдлууд болон тэдгээрийн эсрэг авч хэрэгжүүлсэн хариу арга хэмжээний талаарх мэдээлэл (жишээ нь үр дүн хувирч байгааг олж илрүүлсэн тохиолдлууд, илрүүлсэн явц, менежментийн хариу арга хэмжээ). | • Үндэсний ойн мониторингийн системийн (ҮОМС)-ийн хэрэгжилтийг тайлбарлах, үүнд тайлангийн давтамж, чадавх бэхжүүлсэн тухай мэдээлэл орно г.м.<br>• Үр дүр хувирсан тохиолдлын тоо, баримт, үүнд:<br>- Тохиолдол илэрсэн тоо<br>- Байршил<br>- Ойн бүрхэвч, чанарт үзүүлсэн нөлөө г.м |
| F4. Аливаа үр дүн хувирч, эсрэгээр өөрчлөгдөх тохиолдол гарсан үед түүний шалтгааныг судалж, зохих менежментийн арга хэмжээ авч байх механизмыг REDD+-ийн хяналт, | **Тусгах:**<br>F4.1. Үр дүн хувирсан тохиолдлуудыг илрүүлж мэдээлэх REDD+-ийн Хяналт, үнэлгээний тогтолцоо, тэдгээрийн эсрэг хариу арга хэмжээ | • REDD+-ийн Хяналт, үнэлгээний тогтолцооны онцлогуудыг тайлбарлах, жишээ нь:<br>- Мэдээллийг хэрхэн үнэлж дүгнэдэг тухай |

| | | |
|---|---|---|
| үнэлгээний системд суулгаж өгсөн байна. | авах механизм болон үйл ажиллагаануудын талаарх тайлбар (СНСЗ F3-тай давхацна) | - Үр дүр хувирсан тохиолдолд авах менежментийн арга хэмжээний талаар гэх мэт |
| | **Хэрэгжүүлэх:**<br>F4.2. Үр дүр хувирах тохиолдлын хариуд авах менежментийн арга хэмжээтэй холбоотой мэдээлэл. | • Үр дүр хувирсан тохиолдолд авсан менежментийн арга хэмжээний үр дүнг тайлбарлах:<br>- Шалтгааныг нь тогтоосон тухай<br>- Авсан хариу арга хэмжээ<br>- Хариу арга хэмжээний үр дүн, уг арга хэмжээг хэрэгжүүлэхэд учирсан саад бэрхшээл |
| **Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчим G: Хүлэмжийн хийн ялгаралт өөр газар шилжих явдлыг бууруулах** | | |
| **Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмыг үндэсний нөхцөлд элемент бүрээр тодорхойлсон нь** | **Мэдээллийн хэрэгцээ** | **Шалгуур үзүүлэлтийн агуулга, үндэслэл** |
| G1. Монгол орны REDD+ Хөтөлбөр болон үүний гол хэсэг болох REDD+ БАХ-нүүдийг боловсруулахдаа улсын нийт нутаг дэвсгэрийг аль болох зохих ёсоор хамруулах (ойн болон ой бус экосистемүүдийг оруулах г.м) ба REDD+ арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах шаардлагатай салбар дундын талуудын оролцоог багтаасан байна. | **Тусгах:**<br>G1.1. REDD+ Үндэсний хөтөлбөрт хамрагдсан газар нутгийн тухай мэдээлэл.<br>G1.2. Үндэсний REDD+ хөтөлбөрт салбар хоорондын хамтын ажиллагаа, оролцоог хэрхэн дэмжиж байгаа талаарх мэдээлэх (СНСЗ B4-тэй давхацна).<br>G1.3. БАХ-нүүдэд ойн болон ойн бус экосистемүүд хэрхэн хамрагдсан талаарх мэдээлэл | • Үндэсний REDD+ хөтөлбөрт хамрагдсан орон нутгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн мэдээлэл, экосистем, ойн төрөл<br>• REDD+ Үндэсний хөтөлбөрт хамрагдсан ойн бүрхэвчийн тодорхойлолт (ойн суурь түвшнээс): сэрүүн бүсийн ой ба заган ой г.м<br>• REDD+-ийг хэрэгжүүлэх салбар дундын механизмын талаарх тодорхойлолт (B4-г харна уу)<br>• Ойн бус экосистем (жишээ нь бэлчээр, усны эх ундарга)-д хэрэгжиж байгаа болон эсвэл |

| | | |
|---|---|---|
| | | нөлөөлж байгаа БАХ-нүүдийн талаарх тайлбар |
| | **Хэрэгжүүлэх:**<br>G1.4. REDD+-ийг хэрэгжүүлсэн газар нутгийн хэмжээ (REDD+-ийг хэрэгжүүлсэн газар нутгийн хэмжээ, уг хөтөлбөрт хамрагдсан ой болон экосистемийн төрөл)<br>G1.5. REDD+-ийн салбар хоорондын хамтын ажиллагааг хангах механизмын хэрэгжилттэй холбоотой мэдээлэл (СНСЗ B4-тэй давхацна). | • REDD+ арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж буй газрын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тоо баримт, жишээ нь ойн хомсдол, доройтлыг бууруулах үндэсний дэд хөтөлбөр бүхий аймгуудын тоо, хамрагдсан экосистем болон ойн сангийн төрөл<br>• Ойн бүрхэвч, чанарт нь өөрчлөлт гарч буй ой бүхий газар нутгийн талаар мэдээлэл (ҮОМС-ээс)<br>• Салбар дундын хамтын ажиллагааг хэрэгжүүлсэнтэй холбоотой тоо баримт (B4–г харна уу) |
| G2. REDD+-ийн үйл ажиллагааг төлөвлөх, сонгох, хэрэгжүүлэх болон хяналт тавихдаа ойн хомсдол, доройтолд хүргэж буй голлох шууд болон дам хүчин зүйлсийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаануудыг хамруулахын зэрэгцээ REDD+ арга хэмжээнүүдийг Монгол Улсад тогтвортой хэрэгжүүлэхэд гол тулгуур болох ойн тогтвортой менежмент, хамгааллын үйл ажиллагааг орон нутгийн болон улсын хэмжээнд сайжруулахад саад болж буй бэрхшээлийг шийдвэрлэх арга хэмжээнүүдийг ойн салбарын | G2.1. Ойн хомсдол, доройтолд хүргэж буй голлох шууд болон дам хүчин зүйлсийг REDD+-ийн БАХ-г улсын хэмжээнд боловсруулах явцад тодорхойлсон тухай, мөн тэдгээрийг БАХ боловсруулах ажилд хэрхэн тусгасан талаарх мэдээлэх<br>G2.2. REDD+-ийн Хяналт, үнэлгээний систем нь ойн хомсдол, доройтолд хүргэж буй голлох шууд болон дам хүчин зүйлсийг бууруулахад REDD+-ийн зүгээс үзүүлж буй нөлөөллийг хэрхэн хянаж байгаа талаарх мэдээлэл | • Үндэсний хэмжээнд БАХ-нүүдийг төлөвлөх, REDD+Үндэсний хөтөлбөрийг боловсруулах талаар хэрэгжүүлсэн үйл явцуудын (мөн орон нутагт дэд хөтөлбөр боловсруулсан тухай) тайлбар:<br>- ойн хомсдол, доройтолд хүргэж буй голлох шууд болон дам хүчин зүйлсийн дүн шинжилгээ<br>- БАХ-ний төлөвлөлт, энэ нь ойн хомсдол, доройтолд хүргэж буй голлох шууд болон дам хүчин зүйлстэй хэрхэн холбогдож байгаа талаарх мэдээлэл<br>- Үр ашиг ба эрсдэлийн үнэлгээ (удаан хугацааны тогтвортой байдалд хамаарна) |

| | | |
|---|---|---|
| холбогдох БХЖ-ын дагуу тусгасан байна. | | • БАХ-нүүд нь шууд болон дам хүчин зүйлсийг хэрхэн бууруулж байгаа талаар, мөн тодорхой хүчин зүйлийг бууруулахад чиглэсэн БАХ-ний талаарх тайлбар (шууд болон дам хүчин зүйлсийг шийдвэрлэх асуудлыг тусгасан холбогдох БХЖ-уудтай хэрхэн холбогдсон талаарх тайлбар)<br>• REDD+-ийн Хяналт, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдээр дамжуулж ойн хомсдол, доройтолд хүргэж буй голлох шууд болон дам хүчин зүйлсийг бууруулахад REDD+-ийн зүгээс үзүүлж буй нөлөөллийг хэрхэн хянах талаарх мэдээлэл<br>• Холбогдох шалгуур үзүүлэлтүүд, |
| | **Хэрэгжүүлэх:**<br>G2.3. REDD+-ийн мониторингийн системээр дамжуулан ойн хомсдол, доройтолд хүргэж буй голлох шууд болон дам хүчин зүйлсийг бууруулах чиглэлээр гарч байгаа үр дүнг хянаж байгаа талаарх мэдээлэл. | • Тайлангийн хугацаанд хяналт, үнэлгээг хэрхэн хэрэгжүүлснийг тайлбарлах, жишээ нь давтамж, ямар агентлагаар г.м.<br>• Ойн хомсдол, доройтолд хүргэж буй голлох шууд болон дам хүчин зүйлсийг бууруулахад REDD+-ийн үзүүлж буй нөлөөтэй холбоотой тоо, баримт (дээр дурдсан холбогдох үзүүлэлтүүд ба БАХ дээр үндэслэсэн байна)-ыг бүрдүүлэх |
| G3. REDD+ БАХ-нүүдийг боловсруулахдаа тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлсний улмаас сөрөг нөлөө нь ойн болон ойн бус өөр газарт шилжих эрсдэл үүсэж, ой | **Тусгах:**<br>G3.1. Сөрөг нөлөө шилжих эрсдэлийг хэрхэн тодорхойлж (үүний дотор ойн ба ойн бус бүс болон амьжиргаатай холбоотой) REDD+Үндэсний | • REDD+-ийн эрсдэл ба үр ашгийг улсын болон аймгийн хэмжээнд үнэлсэн талаарх мэдээлэл<br>• Сөрөг нөлөө шилжихтэй холбоотой эрсдэлүүдийн хураангуй |

| | | |
|---|---|---|
| түшиглэж амьдардаг болон бусад төрлийн аж ахуй эрхэлдэг иргэдийн амьжиргаанд нөлөөлөх эрсдэл үүсэж болохыг харгалзан үзсэн байна. Эдгээр эрсдэлийг шинжилж үзсэний үндсэн дээр тэдгээрийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг БАХ-нүүдэд тусгасан байна. | хөтөлбөр боловсруулах явцад тусгасан тухай мэдээлэл<br><br>G3.2. Сөрөг нөлөө шилжих эрсдэлүүдийг бууруулахад чиглэсэн тодорхой БАХ, үйл ажиллагааг Үндэсний REDD+ хөтөлбөр/БАХ-үүдэд хэрхэн тусгасан тухай мэдээлэл. | • Сөрөг нөлөө шилжих эрсдэлийн эсрэг арга хэмжээ авахад дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн БАХ-ний тухай тайлбар<br>• Сөрөг нөлөө шилжих эрсдэлийг бууруулах чиглэлээр тодорхойлсон арга хэмжээнүүдийн тойм |
| | **Хэрэгжүүлэх:**<br>G3.3. Сөрөг нөлөө шилжихтэй холбоотой эрсдэлүүдээс зайлсхийх, бууруулахад чиглэсэн арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой мэдээлэл | • Тодорхой БАХ-г хэрэгжүүлсний үр дүнд сөрөг нөлөө өөр газарт шилжих эрсдэлүүдийг бууруулсан талаарх тоо баримт, үүнд:<br>- Гол хүчин зүйлсийг шийдвэрлэхэд чиглэсэн БАХ-нүүд<br>- Хил дамнасан хамтын ажиллагаатай холбоотой БАХ-нууд<br>- Сөрөг нөлөө өөр газарт шилжих эрсдэлийг бууруулах БАХ-нууд |
| G4. REDD+-ийнүйл ажиллагааг хянах, үнэлэх системд хүлэмжийн хийн ялгаралт буурсан үр дүн хожим хувирах, ялгаралт ой, ойн бус өөр газарт шилжиж байгаа талаарх мэдээллийг илрүүлж, шалтгааныг олж тогтоох давтамжийг тохируулж өгсөн байх ба үүнийг гүйцэтгэхэд шаардагдах боловсон хүчний болон техникийн нөөцийг шийдэж өгсөн байна. | **Тусгах:**<br>G4.1. Сөрөг нөлөөлөл ой, ойн бус талбайд шилжсэн мөн шилжих эрсдэлтэй байгаа талаарх мэдээллийг илрүүлэх тохиргоог Үндэсний ойн мониторингийн систем (ҮОМС)-д хэрхэн суулгасан талаарх тайлбар. Мөн сөрөг нөлөөлөл шилжих гэдгийг юу гэж тодорхойлсон талаарх тайлбар орно.<br><br>G4.2 ҮОМС-д хуваарилсан боловсон хүчин, техникийн нөөцийн хүрэлцээний талаарх мэдээлэл. | • ҮОМС-ийн бүтцийн тухай тайлбар, үүнд:<br>- Үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд<br>- Оролцож ажиллах байгууллагууд<br>- Дүн шинжилгээний төрөл ба тайлангийн давтамж<br>• Монгол улсад хэрэглэгдэж байгаа “сөрөг нөлөө шилжих” гэсэн ойлголтын тодорхойлолтыг тайлбарлах<br>• ҮОМС-д оноосон нөөцийн тухай тайлбар: боловсон хүчин, техник тоног төхөөрөмж, чадавх дээшлүүлэх болон уг системийг |

| | | |
|---|---|---|
| | | ажиллуулахтай холбоотой санхүүжилт г.м |
| | **Хэрэгжүүлэх:**<br>G4.3. Үндэсний ойн мониторингийн систем (ҮОМС)-ийн хэрэгжилттэй холбогдолтой үр дүн, мөн ашигласан боловсон хүчин, техникийн нөөцийн талаарх мэдээлэл.<br>G4.4. Сөрөг нөлөө шилжсэн байж болзошгүй тохиолдол илэрсэн тохиолдол, түүний эсрэг авсан арга хэмжээний тухай мэдээлэл (илэрсэн тохиолдол, илэрсэн үед авсан арга хэмжээ г.м). | • Үндэсний ойн мониторингийн системийн (ҮОМС)-ийн хэрэгжилтийн статистик мэдээ, үүнд тайлан мэдээний давтамж, чадавх бэхжүүлэх үйл ажиллагааны тухай мэдээлэл, дүн шинжилгээний үнэн бодит байдлын талаарх мэдээлэл орно г.м.<br>• Сөрөг нөлөө шилжсэн тохиолдлын тоо, баримт, үүнд:<br>- Тохиолдол илэрсэн тоо<br>- Байршил<br>- Ойн бүрхэвч, чанарт үзүүлсэн нөлөө г.м |
| G5. REDD+-ийнүйл ажиллагааг хянах, үнэлэх системд хүлэмжийн хийн ялгаралт ой, ойн бус өөр газарт шилжиж байгаа талаарх мэдээллийг илрүүлж, сөрөг нөлөө шилжиж байгаагийн цаад шалтгааныг олж тогтоон, зохих менежментийн арга хэмжээг авч байх механизмыг суулгаж өгсөн байна. | **Тусгах:**<br>G5.1. Үр дүн хувирсан тохиолдлуудыг илрүүлж мэдээлэх REDD+-ийн Хяналт, үнэлгээний тогтолцоо, тэдгээрийн эсрэг хариу арга хэмжээ авах механизм болон үйл ажиллагаануудын талаарх тайлбар (СНСЗ F3-тай давхацна). | • REDD+-ийн Хяналт, үнэлгээний тогтолцооны холбогдох онцлогуудыг тайлбарлах, жишээ нь:<br>- Мэдээллийг хэрхэн үнэлж дүгнэдэг вэ<br>- Сөрөг нөлөө шилжсэн тохиолдолд авах менежментийн арга хэмжээ |
| | **Хэрэгжүүлэх:**<br>G5.2. Сөрөг нөлөө шилжсэн тохиолдолд авсан менежментийн хариу арга хэмжээний талаарх мэдээлэл | • Сөрөг нөлөө шилжсэн тохиолдолд авсан менежментийн арга хэмжээний үр дүнг тайлбарлах:<br>- Шалтгааныг тогтоосон<br>- Авсан хариу арга хэмжээ г.м |

# Хавсралт 3: СНСМС-ийн загварын талаарх зөвлөлдөх уулзалт

## 3.1. СНСМС-ийн загварын гол бүрэлдэхүүн хэсгүүдийг боловсруулах семинар (2018 оны 3 сарын 25-27), Техникийн ажлын хэсгийн уулзалт (2018 оны 3 сарын 28)

### 3.1.1. Зорилго

Монгол орны СНСМС-ын зорилгыг тодорхойлох, уг системийг боловсруулахтай холбоотой холбогдох гол мэдээллийг хянан нягталж, мэдээллийн системүүд болон эх үүсвэрүүдэд үнэлгээ хийх нь энэхүү семинарын гол зорилго байлаа. Оролцогчид мэдээллийн систем болон эх үүсвэрүүдэд хийсэн үнэлгээ болон СНСМС-ийн зорилго, СНСМС-ийг ажиллуулах институцийн зохион байгуулалт, гүйцэтгэх үүрэг хариуцлагын талаар хэлэлцэв. Хэлэлцүүлгийн үр дүнд уг мэдээллийг системийг Ойн судалгаа, хөгжлийн төв (ОСХТ) эсвэл Байгаль орчны мэдээллийн төвд (БОМТ) хариуцуулах гэсэн хоёр хувилбарыг санал болголоо.

### 3.1.2 Оролцогчид

Тэрэлжид 3 сарын 26-27-ны өдрүүдэд зохион байгуулсан СНСМС-ийн загварын боловсруулах семинарт 18 хүн (7 эмэгтэй ) оролцсон бөгөөд ихэнх нь СНСМС-ийн мэдээллийн эх үүсвэр, тэдгээрийг боловсруулахтай холбоотой үйл ажиллагааг хариуцдаг төрийн байгууллагуудын төлөөлөгчид байлаа.

| № | Нэр | Албан тушаал | Хүйс |
|---|---|---|---|
| 1 | Д. Жагдаг | БОАЖЯ-ны мэргэжилтэн | Эр |
| 2 | Ц. Банзрагч | Үндэсний зөвлөх | Эр |
| 3 | Шинэцэцэг | Төрийн бус байгууллага | Эм |
| 5 | Амармаа | Мэдээллийн системийн чиглэлээр ажиллаж байгаа үндэсний зөвлөх | Эм |
| 6 | Г. Мөнхзул | ГЗБГЗЗГ-ын газрын нөхцөл байдал чанарын хянан баталгаажуулах мониторингийн сүлжээ хариуцсан ахлах мэргэжилтэн | Эр |
| 7 | Б. Дөл | Техникийн ажлын хэсгийн гишүүн ГЗБГЗЗГ-ын усны нөөц, аялал жуулчлал, сувилалын зориулалтаар ашиглах газрын төлөвлөлт зохицуулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн | Эр |
| 8 | Э. Содномпил | БОАЖЯ-ны мэргэжилтэн | Эр |
| 9 | Р. Отгончимэг | ГЗБГЗЗГ-ын газрын төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн | Эм |
| 10 | З. Нарангэрэл | Техникийн ажлын хэсгийн гишүүн, БОМТ-ын мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн | Эм |
| 11 | Э. Санаа | УАӨТХН-ийн мэргэжилтэн | Эм |
| 12 | Барсболд | ОСХТ, ойн инженер | Эр |
| 13 | Б. Хосбаяр | Техникийн ажлын хэсгийн гишүүн, GIS мэргэжилтэн (ОСХТ) | Эр |
| 14 | Алтангадас | Мэдээллийн сангийн мэргэжилтэн, ОСХТ | Эр |
| 15 | Уянгаа | Техникийн ажлын хэсгийн гишүүн, ҮСГ-ын мэргэжилтэн | Эм |
| 16 | С. Норов | Үндэсний статистикийн хорооны ахлах мэргэжилтэн | Эм |
| 17 | А. Оюунчимэг | Үндэсний статистикийн хорооны мэргэжилтэн | Эр |
| 18 | Б. Отгонсүрэн | Техникийн ажлын хэсгийн дэд дарга, БОАЖЯ | Эр |
| **UN-REDD Programme** | | | |
| 19 | Yeseul Byun | Монгол орны UN-REDD хөтөлбөрийн ОУ-ын зөвлөх | Эм |

| | | | |
|---|---|---|---|
| 20 | Steve Swan | СНСЗ-уудыг олон улсын хэмжээнд хэрэгжүүлэх асуудал хариуцсан зохицуулагч | Эр |
| 21 | David Annandale | Олон улсын зөвлөх | Эр |
| 22 | Charlotte Hicks | UNEP-WCMC-ийн хөтөлбөрийн ажилтан | Эм |
| 23 | Д.Энхжаргал | Монгол орны UN-REDD хөтөлбөрийн СНСЗ-ын асуудал хариуцсан Үндэсний зөвлөх | Эм |
| 24 | Б.Ганчимэг | Туслах ажилтан | Эм |
| 25 | Б.Номинчулуун | Орчуулагч | Эм |
| 26 | Д.Дуламжав | Орчуулагч | Эм |
| 27 | Chris Dickinson | Монгол орны UN-REDD хөтөлбөрийн ТАЗ | Эр |

### 3.1.3 Гол үр дүн

СНСМС-ийн загвар боловсруулах семинараас дараах гол үр дүн гарлаа.Үүнд:

**Мэдээллийн систем болон мэдээллийн эх үүсвэрүүдийг үнэлэх чиглэлээр:** Семинарын үеэр: ГЗБГЗЗГ, УАӨТХН, УАӨТХН, БОМТ, ОСХТ, ҮСГ, БОАЖЯ зэрэг гол гол мэдээллийн систем болон мэдээллийн эх үүсвэрүүдийг танилцуулсан. Семинарт оролцогчид багуудад хуваагдан үнэлгээний хүснэгт дээр ажиллав. Мөн багууд дээрх мэдээллийн системүүдээс СНСЗ тус бүрт хамаарах ямар мэдээ, баримт авч болох талаар тодруулж ажиллав.

**СНСМС-ийн зорилгыг санал болгосон нь**:

Монголд байгуулахаар төлөвлөж байгаа СНСМС-ийн зорилгын талаар дээрх семинарын үеэр болон дараа нь зохион байгуулсан ТАХ-ийн уулзалтын үеэр хэлэлцсэн. Өмнөх семинарын үеэр боловсруулсан зорилгуудын жишээг оролцогчдод танилцуулсан бөгөөд багийн ажлын хүрээнд тэдгээр зорилгыг хэлэлцсэн. Хэлэлцүүлэг нь дараах асуултуудын дагуу өрнөв. Үүнд:

- Монгол Улс нь НҮБ-ийн УАӨСК-оос гадна бусад олон улсын гэрээгээр аливаа сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудтай холбоотой тайлан өгөх үүрэг хүлээсэн үү? Жишээлбэл: REDD+-ийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд санхүүжилт олгосон бусад байгууллагын шаардлагыг биелүүлэхэд энэ СНСМС-ийг ашиглах уу?
- СНСМС нь Канкуны зарчмуудаар хязгаарлагдахгүйгээр өөр бусад өргөн хүрээний мэдээллийг цуглуулах, зохион байгуулах түгээх зэрэг үүрэг гүйцэтгэх үү? Жишээлбэл, : REDD+-ээс өөр үндэсний хэмжээнд хэрэгжүүлж байгаа бусад бодлогын хэрэгжилтийг хянах гэх мэт?
- СНСМС-ийг цаашид явцын дунд алхам алхмаар боловсруулж, сайжруулж байх аргачлалыг баримтлах уу? Жишээлбэл: СНСМС нь одоогоор REDD+-ийн СНСЗ-уудад голлон анхаарсан байх боловч цаашдаа өөр нэмэлт зорилгуудыг тусгаж болно гэх мэт.

Оролцогчид болон техникийн ажлын хэсгийн гишүүд доорх зорилгыг санал болгов:

**Үе шат 1: 2018 - 2020**

- СНС Канкуны зарчмуудыг БХЖ-нд хэрхэн тусган хэрэгжүүлж байгаа талаар тайлагнах

- Уур амьсгалын ногоон сан г.м бусад санхүүжүүлэгч байгууллагуудаас санхүүжилт авах шаардлагыг хангах
- Төрөөс ойн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг дэмжих

**Үе шат 2: 2021 - 2024**

- Ойн салбарт хэрэгжиж байгаа уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох, түүнийг сааруулахтай холбоотой бүх хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар (үндэсний зорилтот хувь нэмэр, үндэсний тайлан зэрэгт мэдээлэл өгнө) тайлагнах

ТАХ-ийн уулзалтын дараа Оролцогчид СНСМС-ийн дээрх зорилгуудын хугацааг Үндэсний REDD+ Хөтөлбөрийн үе шатуудтай нийцүүлэн өөрчлөв (2018-2020, 2021-2024).

Үүнээс гадна СНСМС-ийн зорилго хараахан биш боловч уг системийг боловсруулах явцад мөрдвөл зохих зарчмуудыг дараах байдлаар тодорхойлсон байна :

- Мэдээллийн хүртээмж хэрэглээг сайжруулж өгсөн байх
- СНСМС нь урт хугацаагаар тогтвортой ажиллах
- Салбар хоорондын нэгдсэн мэдээллийн систем байх
- Орон зайн дүн шинжилгээг багтаасан цахим талбар байх.

**СНСМС-ийг ажиллуулах институцийн зохион байгуулалт, үүрэг, хариуцлага:**

| Байгууллага | СНСМС-тэй холбоотой одоогийн гүйцэтгэж буй үүрэг |
|---|---|
| ОСХТ | Ойн салбарын мэдээллийг цуглуулах, шинэчлэх, дүн шинжилгээ хийх, тайлагнах |
| ГЗБГЗЗГ | Газрын тухай мэдээллийг цуглуулах, шинэчлэх, дүн шинжилгээ хийх, тайлагнах |
| ҮСГ | Өөр өөр салбаруудаас мэдээллийг цуглуулж эмхэтгэх, нийгэм эдийн засгийн мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийж, түгээх |
| БОМТ | Яам болон байгууллагуудаас байгаль орчны мэдээллийг цуглуулж, эмхэтгэж түгээх (байгаль орчны хуулийн хүрээнд ) |
| БОАЖЯ | Дүн шинжилгээ хийх, тайлан боловсруулах (Байгаль орчны төлөв байдлын тайлан г.м) |
| УАӨТХН | Уур амьсгалын өөрчлөлтийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх, тайлагнах |
| МХЕГ | Стандарт, зөрчилтэй холбоотой мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх, тайлагнах |
| ОБЕГ | Онцгой нөхцөл байдал болон байгалийн гамшгийн талаарх мэдээллийг цуглуулж, тайлагнаж, түгээх |

| | |
|---|---|
| Цагдаагийн байгууллага | Гэмт хэргийн талаарх мэдээллийг цуглуулж, тайлагнах, мэдээллийг түгээх |
| Байгаль орчны иргэний нийгмийн зөвлөл | Байгалийн нөөцийн ашиглалтын талаарх мэдээллийг цуглуулах, эмхэтгэх, хянах, түгээх |

*СНСМС-ийг хариуцаж ажиллуулах институц, гүйцэтгэх үүрэг, хариуцлагын зохион байгуулалтын 1-р хувилбарыг харуулсан бүдүүвч зураг*




*СНСМС-ийг хариуцаж ажиллуулах институц, гүйцэтгэх үүрэг, хариуцлагын зохион байгуулалтын 2-р хувилбарыг харуулсан бүдүүвч зураг*

**СНСМС- ийг ажиллуулах институцийн зохион байгуулалт, үүрэг хариуцлага – Боломжит хувилбар 2**




### 3.1.4 СНСЗ болон СНСМС боловсруулах техникийн ажлын хэсгийн (СНСЗ-СНСМС-ийн ТАХ) уулзалтын хэлэлцүүлэг

Семинарын дараа СНСЗ болон СНСМС боловсруулах техникийн ажлын хэсгийн (СНСЗ-СНСМС-ийн ТАХ) уулзалтыг Улаанбаатар хотноо зохион байгуулсан бөгөөд үүнд 39 хүн оролцсон (22 эмэгтэй). Уулзалтад СНСЗ болон СНСМС-ийн техникийн ажлын хэсгийн гишүүд мөн (хэмжилт, тайлагналт, баталгаажуулалтын асуудал хариуцсан техникийн ажлын хэсэг зэрэг) бусад холбогдох ТАХ-ийн гишүүд болон СНСМС-ийн мэдээллийн эх үүсвэр, түүнийг хөгжүүлэхтэй холбоотой асуудлыг хариуцах төрийн гол байгууллага, агентлагийн ажилтнууд, монгол орны UN-REDD хөтөлбөрийн мэргэжилтнүүд болон UN-REDD хөтөлбөрийн бүсийн болон олон улсын зөвлөхүүд оролцсон.

Энэ уулзалтын үеэр СНСЗ-уудыг үндэсний нөхцөлд нийцүүлж тодорхойлсон төсөл, мэдээллийн систем болон эх үүсвэрүүдэд хийсэн үнэлгээний эхний үр дүн, СНСМС-ийн загварыг боловсруулах семинараас гарсан үр дүнг танилцуулж, энэ гурван ажлын үр дүнг багаар хэлэлцүүлэв.

СНСМС-ийн загварын бүрэлдэхүүн хэсгүүдийн талаар оролцогчид дараах саналуудыг дэвшүүлэв:

- СНСМС-ийн зорилтуудыг санал болгосныг хүлээн зөвшөөрсөн. Гэхдээ зорилтуудын хамрах хугацааг REDD+Үндэсний хөтөлбөрийн төслийн хугацаатай уялдуулж өөрчлөхийг зөвлөв.
- Мэдээллийн систем, эх үүсвэрүүдийг үнэлэх болон хожим СНСМС-ийг ажиллуулахад шинжлэх ухааны байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудын гүйцэтгэх үүрэг ямар байх талаар асуулт тавьж байсан. Хэдийгээр СНСМС-д үндэсний хэмжээнд батлагдсан, албан ёсны мэдээ баримтыг оруулах, мэдээг улсын хэмжээнд тогтмол цуглуулж байх шаардлагатай ч, үнэлгээний үеэр эрдэм шинжилгээний

байгууллагууд болон иргэний нийгмийн төлөөлөгчидтэй уулзаж байна. Үүнээс гадна, СНСЗ-ын талаарх мэдээллийг хянах болон баталгаажуулахад эдгээр байгууллага гол үүрэг гүйцэтгэнэ гэж үзэж байна.

- СНСМС-ийг хариуцах институцийн үүрэг, хариуцлагын тухайд СНСМС-ийг удирдаж ажиллуулах байгууллагатай холбоотой тодорхой санал гараагүй. Семинарын үеэр дэвшүүлсэн хоёр хувилбарыг цаашид судалж, үнэлнэ.

## 3.2. "Сөрөг нөлөөллөөс сэргийлэх мэдээллийн систем (СНСМС)-ийн загварын бүрэлдэхүүн хэсгүүд" сэдэвт семинар (2018 он 6 сарын 19)

### 3.2.1 Зорилго

Уг семинарын зорилго нь оролцогчдод Монгол орны REDD+-ийн СНСМС-ийн загварын бүрэлдэхүүн хэсгүүд ямар байх талаар өмнө дэвшүүлсэн саналыг танилцуулж, хянуулан саналыг нь авах, СНСМС-ийн загварын бүрэлдэхүүн хэсгүүдийн талаар оролцогчдод тодорхой мэдлэг ойлголт өгөхөд оршиж байв..

### 3.2.2 Оролцогчид

Уг семинарт СНСЗ-ууд болон СНСМС-ийг боловсруулах техникийн ажлын хэсгийн гишүүдээс гадна бусад техникийн ажлын хэсгийн гишүүд (ХТБ), СНСМС-тэй чиг үүргийн хувьд холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөгчид оролцлоо. Нийт 40 хүн (23 эмэгтэй) оролцсон.

| № | Нэр | Албан тушаал | Хүйс |
|---|---|---|---|
| **Техникийн ажлын хэсгийн гишүүд** | | | |
| 1 | Ц. Банзрагч | Үндэсний зөвлөх, UN-REDD | Эр |
| 2 | Дөл | ГЗБГЗЗГ-ын мэргэжилтэн | Эр |
| 3 | З. Нарангэрэл | БОМТ-ийн мэргэжилтэн | Эм |
| 4 | А. Оюунчимэг | Техникийн ажлын хэсгийн гишүүн | Эм |
| **Байгууллагууд** | | | |
| 5 | Ч. Болдбаатар | Монгол улсын Шинжлэх ухаан технологийн их сургууль | Эр |
| 6 | Тодгэрэл | Монгол улсын Шинжлэх ухаан технологийн их сургууль | Эм |
| 7 | Батсайхан | Гео-экологийн хүрээлэн | Эр |
| 8 | Баттулга | Гео-экологийн хүрээлэн | Эр |
| **Агентлагууд** | | | |
| 9 | Мөнхзул | ГЗБГЗЗГ-ын ахлах мэргэжилтэн | Эр |
| 10 | Барсболд | ОСХТ, ойн инженер | Эр |
| **Хувийн компаниуд** | | | |
| 11 | Баярсайхан | "Хөвчийн хоймор" компани | Эр |
| **Монгол орны байгаль орчны иргэний нийгмийн зөвлөлүүд** | | | |

| | | | |
|---|---|---|---|
| 12 | Төмөрмөнх | Монгол орны иргэний нийгмийн зөвлөлийн гишүүн | Эр |
| 13 | Д. Саранчимэг | Монгол орны иргэний нийгмийн зөвлөлийн гишүүн | Эм |
| 14 | О. Мөнхзул | Монгол орны иргэний нийгмийн зөвлөлийн гишүүн | Эм |
| 15 | М.Болорсайхан | Монгол орны иргэний нийгмийн зөвлөлийн гишүүн | Эм |
| 16 | Б. Чулуунсүрэн | Монгол орны иргэний нийгмийн зөвлөлийн гишүүн | Эм |
| **Бусад төрийн бус байгууллагууд** | | | |
| 17 | Шинэцэцэг | “Сайн хөрш” төрийн бус байгууллагын мэргэжилтэн | Эм |
| **Ойн тогтвортой хөгжлийн зөвлөл** | | | |
| 18 | Болдбаатар | Ойн тогтвортой хөгжлийн зөвлөлийн гишүүн | Эр |
| 19 | Бадамханд | Ойн тогтвортой хөгжлийн зөвлөлийн гишүүн | Эм |
| 20 | Аюуш | Ойн тогтвортой хөгжлийн зөвлөлийн гишүүн | Эр |
| **Орон нутгийн мэргэжилтэн, албан хаагчид** | | | |
| 21 | Жавхлан | Ойн ангийн инженер | Эм |
| 22 | Мөнхсайхан | Дорнод аймгийн ойн ангийн дарга | Эм |
| 23 | Нансалмаа | Дорнод аймгийн БОАЖГ-ын мэргэжилтэн | Эм |
| 24 | Нямхатан | Хэнтий аймгийн ойн ангийн дарга | Эр |
| 25 | Гүрсүрэн | Хэнтий аймгийн БОАЖГ-ын мэргэжилтэн | Эм |
| 26 | Өлзийхишиг | Дархан-уул аймгийн ойн ангийн газрын инженер | Эм |
| 27 | Баасансүрэн | Архангай аймгийн БОАЖГ-ын мэргэжилтэн | Эр |
| 28 | Мөнхзул | Дархан аймгийн БОАЖГ-ын мэргэжилтэн | Эм |
| 29 | Б. Отгонжаргал | Булган аймгийн БОАЖГ-ын мэргэжилтэн | Эм |
| 30 | Болормаа | Хөвсгөл аймгийн байцаагч | Эм |
| 31 | Батмагнай | Ойн ангийн инженер | Эр |
| 32 | Энхбаяр | Төв аймгийн БОАЖГ-ын мэргэжилтэн | Эр |
| 33 | Борчулуун | Сүхбаатар аймгийн БОАЖГ-ын мэргэжилтэн | Эм |
| 34 | Цэнгэлзаяа | Сэлэнгэ аймгийн ойн ангийн дарга | Эм |
| 35 | Отгон-Эрдэнэ | Сүхбаатар аймгийн БОАЖГ-ын мэргэжилтэн | Эм |
| 36 | Банзрагч | Завхан аймгийн БОАЖГ-ын мэргэжилтэн | Эр |
| 37 | Цэрэнсугир | Дундговь аймгийн БОАЖГ-ын мэргэжилтэн | Эм |
| 38 | Дашцэдэн | Говьсүмбэр аймгийн БОАЖГ-ын мэргэжилтэн | Эр |
| 39 | Энхтуяа | Увс аймгийн БОАЖГ-ын мэргэжилтэн | Эм |
| 40 | Цэрэнлхам | Хөвсгөл аймгийн БОАЖГ-ын мэргэжилтэн | Эм |
| **UN-REDD хөтөлбөр** | | | |

| | | | |
|---|---|---|---|
| 41 | Б. Хишигжаргал | Хөтөлбөрийн менежер | Эр |
| 42 | Ш. Хикс | UNEP-WCMC-ийн техникийн ахлах ажилтан | Эм |
| 43 | Мириам Гута | UNEP-WCMC-ийн Хөтөлбөрийн ажилтан | Эм |
| 44 | Д. Дуламжав | Орчуулагч | Эм |
| 45 | Ж. Амармаа | UN-REDD хөтөлбөрийн үндэсний зөвлөх | Эм |
| 46 | Д. Энхжаргал | Монгол орны UNREDD хөтөлбөрийн үндэсний зөвлөх | Эм |

### 3.2.3 Гол үр дүн

Оролцогчид багуудад хуваагдан мэдээллийн бүтэц, институцийн үүрэг, зохион байгуулалт, СНСМС-ийн архитектур буюу бүтэц, СНСМС-ээс гарах мэдээлэл түүнийг түгээх арга замууд зэрэг СНСМС-ийн тодорхой хэсгүүдэд анхаарал хандуулж ажиллаа.

**Баг 1: Мэдээллийн бүтэц**

1-р баг СНСМС дэх мэдээллийг хэрхэн зохион байгуулах талаар хэлэлцээд хэд хэдэн шалгуур үзүүлэлтийн жишээг боловсруулав. Тухайлбал, СНСЗ А-1.3 “Дурьдсан конвенц, хөтөлбөрүүдийн холбогдох зорилго/зорилтуудтай шууд нийцсэн REDD+ -ийн БАХ-нүүдийн үр дүн (жишээ нь биологийн олон янзыг хамгаалах чиглэлээр бүс нутагт хэрэгжүүлэх менежмент сайжирсан, хуурай газрын ойд нөхөн сэргээлт хийсэн га талбай г.м.)” гэсэн мэдээллийн хэрэгцээний шалгуур үзүүлэлт нь ойн талбай /га/, ойн зурвас /га/, байгалийн сэргэн ургалт бүхий талбай /га/, зарцуулсан хөрөнгө /сая төгрөг/, мод үржүүлгийн хүчин чадал /га/, тарьц, суулгац /мян.ширхэг/, тарьсан модны амьдралтын хувь /%/, таримал ойн хэмжээ /га/ зэрэг байж болно.

СНСЗ D– 3.2 “REDD+-ийг хэрэгжүүлэх, мониторинг хийхэд салбар дундын зохицуулалтыг хангах механизм/платформуудын ашиглалттай холбоотой үр дүн (жишээ нь зохион байгуулсан хурал, уулзалтууд, хэрэгжүүлсэн хамтын ажиллагаа)” гэсэн мэдээллийн хэрэгцээний шалгуур үзүүлэлтүүд нь уулзалтууд /зохион байгуулсан уулзалтын тоо/, зөвлөлдөх уулзалт /хэлэлцүүлгийн тоо/, оролцогчдын тоо, БАХ-нүүдэд өгсөн санал, өгсөн санал, зөвлөмжийн тоо зэрэг байж болно.

Зарим тодорхой мэдээллийн хэрэгцээнүүдийн шалгуур үзүүлэлтүүдийг нэмж санал болгосныг доорх хүснэгтэд үзүүлэв:

| **Сөрөг нөлөөллөөс сэргийлэх Зарчим А: Тухайн үйл ажиллагаа нь ойн үндэсний хөтөлбөр, холбогдох олон улсын гэрээ, хэлэлцээрүүдийн зорилгод хувь нэмэр оруулахуйц буюу эсвэл тэдгээрт нийцсэн байна** | | |
|---|---|---|
| **Үндэсний тодорхойлолт** | **Мэдээллийн хэрэгцээ** | **Шалгуур үзүүлэлт/ хэмжигдэхүүн** |
| А3. REDD+-ийн БАХ-нүүд нь МУ-ын Засгийн газраас ядуурлыг бууруулах, тогтвортой хөгжлийн дэмжих чиглэлээр хэрэгжүүлж байгаа Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр, Монгол Улсын Тогтвортой | **Тусгах:**<br>А3.1 REDD+Үндэсний хөтөлбөр нь Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 болон олон улсын Тогтвортой хөгжлийн зорилтуудад тусгагдсан холбогдох зорилго/ зорилттой хэр нийцэж мөн/эсвэл дэмжиж байгааг тодорхойлох.<br>А3.2 Эдгээр үзэл баримтлал, бодлого, хөтөлбөрүүдийн холбогдох | - Ойн салбарт ажиллагсдын тоо<br>- Тухайн жилд ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэхэд түр ажил эрхэлж буй ажилчдын тоо<br>- Шинээр байгуулагдсан мод боловсруулах үйлдвэрийн тоо |

| | | |
|---|---|---|
| хөгжлийн хэтийн төлөв 2030, Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтуудад зорилтуудад нийцсэн байна. | зорилго/зорилтуудтай шууд нийцэж, уялдаж байгаа БАХ-уудыг тодорхойлох. | |
| | **Хэрэгжүүлэх:**<br>A3.3 Дурдсан үзэл баримтлал, бодлого, хөтөлбөрүүдийн холбогдох зорилго/зорилтуудтай шууд нийцэж, уялдаж байгаа, дээр тодорхойлсон REDD+ -ийн БАХ-уудын хүрээнд хүрэх үр дүн (жишээ нь нийгэм-эдийн засагт үзүүлсэн эерэг нөлөөлөл болон хамгаалах чиглэлийн үйл ажиллагаанд үзүүлсэн үр дүн г.м) | |
| **Сөрөг нөлөөллөөс сэргийлэх Зарчим B: - (b) Хууль эрхзүй, бие даасан байдлыг харгалзан үзсэн ил тод, үр дүнтэй үндэсний ойн засаглалын бүтэцтэй байх** | | |
| **Үндэсний тодорхойлолт** | **Мэдээллийн хэрэгцээ** | **Шалгуур үзүүлэлт / хэмжигдэхүүн** |
| B2. МУ-ын Засгийн газар нь ойн засаглалыг үр дүнтэй хэрэгжүүлэх, хөтөлбөрийн хэрэгжилтийг цаашид сайжруулж байх үүднээс REDD+-ийг хэрэгжүүлэхэд оролцох байгууллагуудад төсвийн болон бусад нөөцийг (боловсон хүчин, технологи, сургалт) хуваарилна. | **Тусгах:**<br>B2.1. REDD+ -н хэрэгжилттэй холбогдолтой агентлагуудад үзүүлсэн төсвийн болон бусад нөөцийн (боловсон хүчин, технологи, сургалт) хуваарилалтын талаарх мэдээлэл.<br>B2.2 Тухайн холбогдох агентлагуудын урт хугацаанд эдгээр нөөцийн хуваарилалт болон ашиглалтыг сайжруулах төлөвлөгөөний талаар мэдээлэл. | - Мэргэжлийн боловсон хүчний тоо хэмжээ<br>- Зохион байгуулсан сургалтын тоо<br>- Сургалтад хамрагдсан хүний тоо<br>- Мэргэжил дээшлүүлсэн хүний тоо |
| | **Хэрэгжүүлэх:**<br>B2.3 REDD+ -н хэрэгжилтийг хангах зорилгоор олгосон санхүүжилт болон зарцуулалтын талаарх мэдээллийг холбогдох агентлаг тус бүрээр. | - Тухайн жилд ойг хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулсан зардлын хэмжээ /сая,төг/<br>- Үүнээс эх үүсвэр тус бүрээр |
| B3. REDD+ БАХ-нууд нь Ойн тухай хуулийн хүрээнд ТОМ-ийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой институцын болон хүний нөөцийн чадавх бэхжүүлэх үйл ажиллагааг багтаасан байна. | **Тусгах:**<br>B3.1. Одоо байгаа эсвэл шинээр бий болгох Тогтвортой ойн менежмент (ТОМ)-ийн төлөвлөгөөнүүдийг дэмжсэн БАХ-уудыг тодорхойлох.<br>B3.2. ТОМ-ийн төлөвлөгөөнүүдийн хэрэгжилтийн хүрээнд байгууллагын бүтцийг бий болгох, техникийн чадавхи бэхжүүлэх чиглэлийн арга хэмжээг шууд дэмжсэн БАХ-уудыг тодорхойлох. | |
| | **Хэрэгжүүлэх:**<br>B3.3. ТОМ-ийн төлөвлөгөөнүүдийг хэрэгжүүлэх болон шинээр боловсруулах (байгууллагын бүтцийг бий болгох, техникийн чадавхи бэхжүүлэх зэргийг оруулсан) үйл ажиллагааг дэмжсэн, дээр тодорхойлсон БАХ-уудаас гарах/гарсан үр дүн (жишээ нь шинээр боловсруулсан төлөвлөгөөнүүдийн тоо, төлөвлөгөөний хэрэгжилтэнд зориулж олгосон | - ОМТ-төлөвлөгөөгөө батлуулсан эсэх /аймаг, сум бүрээр/<br>- ОМТ-ний хэрэгжих хугацаа/<br>- Хэрэгжилийн үр дүн /хувиар/<br>- ОМТ хэрэгжүүлэх нийт зардал сая төг/үйл ажиллагаа |

| | | |
|---|---|---|
| | санхүүжилт, чадавхи бэхжүүлэх чиглэлийн арга хэмжээ г.м). | болон эх үүсвэр тус бүрээр/ |
| В7. REDD+ БАХ нь жендерийн тэгш байдлыг болон Жендерийн тухай хуулийг дэмжсэн байна. | **Тусгах:**<br>В7.1. REDD+ нь жендерийн тэгш байдлыг болон Жендерийн тухай хуулийг хэрхэн дэмжиж байгааг тайлбарласан байдал. | - Ойн салбарт ажиллагдсын тоо/хүйсээр/<br>- Албан тушаалын ангиллаар/хүйсээр/ |
| | **Хэрэгжүүлэх:**<br>В7.2. Хүйсийн эрх тэгш байдал, ялангуяа ашгийн эрх тэгш хуваарилалт, оролцоо, ажил эрхлэлт, газар болон ой ашиглах эрх зэргийг дэмжин сурталчилах чиглэлийн REDD+ -ийн БАХ-уудын хэрэгжилтийн үеэр авсан арга хэмжээнүүдийн үр дүнг тодорхойлох | - Ойн салбарт ажиллагсдын цалингийн дундаж хэмжээ /хүйсээр, мянган төгрөг/ |
| В8. REDD+ БАХ-г Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн холбогдох зүйл, заалтуудтай нийцүүлж боловсруулж, хэрэгжүүлэх ба БАХ-нүүдийн талаарх мэдээлэл ил тод, хүртээмжтэй байх бөгөөд холбогдох талуудад мэдээллийг тохирох аргаар хүргэнэ. | **Тусгах:**<br>В8.1. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн холбогдох зүйл, заалтууд Үндэсний REDD+ хөтөлбөрд REDD+ ийн БАХ-ууд мөн REDD+ ийн үйл явцуудыг оролцуулаад, хэрхэн тусгагдсан болохыг тодорхойлох (зүйл, заалтаас хамааран мэдээлэл хуваалцах явц, талуудын оролцоог хангах гэх мэт зарчмуудыг нэрлэж болно) | |
| | **Хэрэгжүүлэх:**<br>В8.2. REDD +ийн БАХ-г хэрэгжүүлэх явцад мэдээллийг хэрхэн хүртээмжтэй болгох талаархи үр дүн:<br>- Хэдийд ямар мэдээллийг хүргэсэн,<br>- Хэн мэдээллийг хэнтэй хуваалцсан ,<br>- Өөр өөр оролцогч талуудад тохиромжтой байдлаар ашиглах талаар тэрхүү мэдээллийг хэрхэн түгээсэн | - Мэдээлэл, сурталчилгаа хийсэн ажлын тоо/мэдээллийн хэрэгсэл тус бүрээр/<br>- Хамрагдсан хүний тоо/<br>- Мэдээлэл хүргэсэн арга, хэрэгсэл |

**2, 3-р багийн ажил: Институцийн гүйцэтгэх үүрэг, зохион байгуулалт**

2, 3-р багууд институцийн зохион байгуулалттай холбоотой асуудлыг хэлэлцлээ. Багийн ажлыг дараах 2 диаграмд харууллаа. Институцийн бүтэцтэй холбоотой энэ 2 саналын хооронд нэг их ялгаа байхгүй бөгөөд 4-р зурагт харууллаа.

## Баг 2: Институцийн гүйцэтгэх үүрэг /өгсөн саналыг улаанаар тэмдэглэв/



**Баг 3: Институцын зохион байгуулалт**



**Баг 3. СНСМС-ийн бүтэц**

3-р баг мэдээллийг цуглуулж зохион байгуулахтай холбоотой асуудалд төвлөрч ажилласан. Багийн ажлаас дараах 3 хувилбарыг боловсруулсныг доор харууллаа.

1-р хувилбарт, мэдээлэл цуглуулах үүрэгтэй байгууллагууд нь мэдээллийн тусгай маягтуудыг бөглөх бөгөөд энэ нь автоматаар статистикийн тайланд тусгагдаж, СНСМС-д орно. 2-р хувилбарт, мэдээлэл цуглуулдаг байгууллагууд нь тусгай маягтуудыг бөглөөд “СНСМС-ийн админ”-д илгээх бөгөөд түүнийг нь хүлээж авсан админ цааш нь СНСМС-д оруулна. 3-р хувилбарт, СНСМС-ийн админ нь мэдээлэл өгдөг байгууллагуудаас өөрөө мэдээллээ цуглуулж аваад “мастер маягт” боловсруулж түүнийгээ СНСМС-д оруулдаг байх юм. БОМТ-ийн одоо байгаа мэдээллийн сангаас мэдээг авч нэгтгэж болох хувилбарыг яагаад гаргаж ирээгүй нь ойлгомжгүй байна.

1)




2)




1. Эксел маягт бөглөнө
2. СНСМС-ийн админ руу илгээнэ
3. Бүх эксел маягтыг цуглуулж нэгдсэн нэг маягтад оруулна (экселийн гол маягт)
4. Эксел файлуудыг СНСМС-д оруулах

3)




1. СНСМС-ийн админ мэдээлэл цуглуулна
2. Мэдээллийг эксел файлд оруулах эсвэл эксел маягт руу хуулж оруулах

**Баг 4: СНСМС болон сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмын талаар олон нийтэд мэдээлэх**

4-р баг нь СНСМС-ээс гарах мэдээллийг хэрхэн өөр өөр зорилтот оролцогч бүлгүүдэд түгээх талаар асуудал дэвшүүлж ажиллаа. Тус багийн ажлаас гарсан үр дүнг дараах хүснэгтэд үзүүллээ. REDD+-ийн мэдээллийг түгээх суваг, СНСЗ-уудын талаар ерөнхийд нь хэлэлцсэн болохыг анхаарна уу.

***А) Зорилтот бүлэг: Эмзэг бүлгийн иргэд /хөгжлийн бэрхшээлтэй иргэд/ үндэстний цөөнх***

| **Сэдэв** | **Сувгууд** |
|---|---|
| REDD+ -ийн ерөнхий тайлан | Телевизийн хөтөлбөр, ном хэвлэлийг эх хэлээр нь түгээх |
| СНСЗ-уудын товч танилцуулга | Телевизийн хөтөлбөрийг дохионы хэлээр явуулах |
| Байгалийн нөөцийн төлөв байдал, түүнд оролцох боломж | Монголын хэвлэл мэдээллийн сувгууд |
| Жич: Багийн дарга, ахлагч бүлгийн ахлагчдыг мэдээлэл цуглуулахад дайчилж ажиллуулж болно. | |

***Б) Зорилтот бүлэг: Хүүхэд, залуучууд***

| **Сэдэв** | **Сувгууд** |
|---|---|
| REDD+ -ийн үйл ажиллагаа, үр дүн | Ном дэвтрийн хавтсан дээр хэвлэх |
| БХЖ, үр ашиг, чадавх бэхжүүлэх хөтөлбөрүүд | Хүүхдийн оролцооны байгууллагууд |
| Доройтсон газрын төлөв байдал, түүний сөрөг нөлөө | Залуучуудын байгууллагууд |
| Бодлого, арга хэмжээ, хувь нэмэр, оролцоо | Сургуулийн өмнөх боловсролоор дамжуулах |
| Сайн дурын оролцогчид, оюутнууд | Фэйсбүүк, инстаграмм, твиттер |
| Тэмцээн, уралдаан зохион байгуулах | Утасны аппликэйшн /тоглоом/<br>Олон улсын болон үндэсний хэмжээнд тэмдэглэдэг өдрүүд<br>- Усны өдөр<br>- Ойн өдөр<br>- Цөлжилттэй тэмцэх дэлхийн өдөр Хүрээлэн буй орчноо хамгаалах дэлхийн өдөр<br>- 5, 10 сар (мод тарих өдөр) |
| Бусад суваг: TV сурталчилгаа, хүүхэлдэйн кино, манга ном, мэдээллийн самбар, кино театрын дэлгэцэнд кино эхлэхээс гардаг зар, баримтат кино /жүжиг/, тээврийн хэрэгсэлд зурагт хуудас наах г.м. | |

***В) 21 аймаг болон сумдын захиргаа***

| **Сэдэв** | **Сувгууд** |
|---|---|
| REDD+ -ийн ерөнхий тайлан | Засаг даргын тамгын газрын цахим хуудас |
| СНСЗ-ийн хэрэгжилтийн тайлан | Уулзалт, хэлэлцүүлэг, сургалт |
| БХЖ-ийн өөрчлөлт, хэрэгжилт | И-мэйл |
| Бусад сувагт: Файсбүүк групп, БОАЖЯ-ны цахим хуудас, ТВ, сонин, сэтгүүл (мэргэжлийн) | |

***Г) Иргэд, ойн нөхөрлөл, малчдад***

| **Сэдэв** | **Сувгууд** |
|---|---|
| Байгалийн нөөцийг ашиглах, хамгаалах (ой, хөрс, ус, биологийн төрөл зүйл, дархан цаацтай газар нутаг) | Багийн хурал |
| | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |

| | |
|---|---|
| СНСЗ-уудын хэрэгжилт, тэргүүн туршлагууд, REDD+-ийн тайлан | Орон нутгийн ТВ, вэбсайт, Фэйсбүүк групп, сэтгүүл, радио |
| | Үндэсний мэдээллийн хэрэгслүүд (МОНТ, Монгол HD, Малчин ТВ, Боловсрол ТВ, TV9, Үндэсний радио, Байгаль орчны сонин, Хөдөөгийн мэдээ, “Монгол орны ой” сэтгүүл, “Монгол коммент” ТВ нэвтрүүлэг) |
| | Мэдээллийн сайтууд дээрх лого, сурталчилгаа (news.mn, ikon.mn, gogo.mn) |
| | Ам дамжуулан ярих |
| | Нийгмийн сүлжээ |
| | Автобус, галт тэрэг, онгоцонд сурталчилгаа байршуулах |
| | Эмнэлэг, зах, дэлгүүр |
| | Тусгай хамгаалалттай нутаг, амрал сувилалын газруудад мэдээлэл самбар тавих |
| | Байгаль хамгаалагч болон орон нутгийн удирдлагуудын мэдээлэл түгээх боломжийг сайжруулах |
| | Нөхөрлөлийн холбоо, ТББ ууд |
| | Уулзалт, сургалт, хэлэлцүүлэг |
| | Онцгой тэмдэглэлт өдрүүд |
| | Үзвэр үйлчилгээний тасалбар, бараа бүтээгдэхүүний шошгон дээр хэвлэх |
| | Тараах материал болон брошюр |
| | Мэссэж /БОАЖЯ/ |
| | Дууны нэвтрүүлэг |
| | Ойн тогтвортой хөгжлийн зөвлөл |
| | Мэдээллийн электрон самбар |
| | Ахмадын холбоо |
| | Монголын хүрээлэн буй орчны иргэний зөвлөл-салбар 21 |
| | Монголын хүрээлэн буй орчноо хамгаалах зөвлөл – салбар 28 |

## 3.3. Сөрөг нөлөөллөөс сэргийлэх мэдээллийн системийг ажилд оруулах тухай хурал (2018 оны 9 сарын 5-6)

Хуралд цөөн тооны техникийн ажилтнууд болон мэргэжилтнүүд оролцсон ба СНСМС-ийн бүтцийг улам боловсронгуй болгох, ирээдүйд СНСМС-ийг ажилд оруулах хэрэгцээ зэрэг асуудал дээр төвлөрлөө. Хурлыг 2018 оны 9 сарын 5-6-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо Байгаль орчны мэдээллийн төв (БОМТ) дээр зохион байгуулав.

### 3.3.1 Зорилго

Уг хурлын зорилгуудыг дурьдвал:

1. Монгол улсын СНСМС-ийг бүтэц дэх элементүүдийн хэлэлцүүлгийг эцэслэх

2. СНСМС-д нэн тэргүүнд шаардлагатай мэдээллийн сангууд болон эх үүсвэрүүдэд хамаатай мэдээллийн цоорхойг нөхөх

3. СНСМС-ийг ажилд оруулахыг шаардаж буй техникийн, улс төрийн, санхүүгийн болон бусад хэрэгцээг авч хэлэлцэх

### 3.3.2 Оролцогчид

Хуралд Байгаль орчны мэдээллийн төв (БОМТ), Ойн судалгаа, хөгжлийн төв (ОСХТ), Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар (ГЗБГЗЗГ), Үндэсний статистикийн хороо (ҮСХ) болон Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ) зэрэг СНСМС-ийг бий болгоход оролцох магадлалтай гол байгууллагуудын төлөөлөл 13 хүн (үүний дотор 6 эмэгтэй) оролцов.

| № | Нэрс | Албан тушаал | Хүйс |
|---|---|---|---|
| ***UN-REDD хөтөлбөр*** | | | |
| 1 | Д. Энхжаргал | Үндэсний зөвлөх | эм |
| 2 | Ж. Амармаа | Үндэсний зөвлөх | эм |
| 3 | Д. Дуламжав | Орчуулагч | эм |
| 4 | Шарлотт Хикс | ДБХАТ-ийн мэргэжилтэн | эм |
| 5 | Хонгор | Үндэсний зөвлөх | эр |
| ***Техникийн ажлын хэсэг болон бусад оролцогчид*** | | | |
| 6 | Уянгаа | ҮСГ-ын мэргэжилтэн | эм |
| 7 | Батзориг | ҮСГ-ын мэргэжилтэн | эр |
| 8 | Алтангадас | ОСХТ, ойн инженер | эр |
| 9 | Б. Хосбаяр | ОСХТ, ойн инженер | эр |
| 10 | З. Нарангэрэл | БОМТ-ын ойн мэргэжилтэн | эм |
| 11 | Б.Вандандорж | БОМТ, , GIS мэргэжилтэн | эр |
| 12 | Г. Мөнхзул | ГЗБГЗЗГ-ын ахлах мэргэжилтэн | эр |
| 13 | Эрдэнэбаяр | ГЗБГЗЗГ-ын мэргэжилтэн | эр |
| 14 | Одбаяр | БОАЖЯ-ны мэргэжилтэн | эр |
| 16 | Д. Жагдаг | БОАЖЯ-ны мэргэжилтэн | эр |
| 17 | Ананд | БОАЖЯ-ны мэргэжилтэн | эм |
| 18 | Ууганцэцэг | ОСХТ | эм |
| 19 | Ганчимэг | Туслах ажилтан | эм |

### 3.3.3 Гол үр дүн

Хурлын үеэр хэлэлцүүлгийн гурван гол хүрээнд анхаарлаа хандуулсан ба үүнд: СНСМС-ийн хамгийн чухал, тэргүүлэх мэдэллийн сангуудын тухай бүрэн ойлголттой болох, санал болгож буй байгууллагын зохицуулалтыг авч үзэх ба СНСМС-ийг бий болгох үйл ажиллагааны хэрэгцээг авч хэлэлцэх зэрэг байв.

**Нэн тэргүүний гэх мэдээллийн сангийн мэдээлэл**

Мэдээллийн систем ба эх үүсвэрийн үнэлгээний үр дүнгийн танилцуулгын дараа оролцогчид өөрсдийн байгууллагын дагуу бүлгүүдэд хуваагдсан. Тэд өөрсдийн мэдээллийн системийн талаар сүүлчийн бүлэг асуултыг авч хэлэлцсэн ба дараах сэдвүүдийг хэлэлцэв: аймгийн түвшинд өгөгдлийг хэрхэн цуглуулдаг болох, тодорхой маягтын агуулга, мөн улсын түвшинд өгөгдлийг хэрхэн нэгтгэдэг болох.

Нэгдсэн хэлэлцүүлгийн үеэр дараах асуудлыг хөндөв:

- ГЗБГЗЗГ эсвэл ОСХТ-ийн аль нь ойн бүрхэвчийн өөрчлөлтийг мэдээлэх ёстойг хэлэлцэх үед ГЗБГЗЗГ нь ой бүхий газрын мэдээллийг зөвхөн 5 ангиллаар дамжуулдаг бөгөөд нь илүү нарийвчилсан ангилал ашигладаг болохыг тэмдэглэсэн. Ашигладаг мэдээллийн эх сурвалж ба аргууд нь бас өөр. ОСХТ мөн газрын хайгуул хийдэг бол ГЗБГЗЗГ сумдын газрын мэргэжилтнээс авсан өгөгдлийг ашигладаг.
- ОСХТ-ийн татварын тооллогын мэдээлэл 10 жил тутам гардаг, ойн нөөцийн мэдээллийн санг жил бүр шинэчилдэг (ОМ маягт гэхдээ заримдаа хуучин мэдээлэл ашигладаг). ГЗБГЗЗГ мэдээллээ жил бүр цуглуулдаг.
- СНСМС-д ойн бүрхэвчийн мэдээллийг ашиглахдаа ҮОМС ба хяналт тайлан шалгалтад ямар мэдээлэл ашиглаж буйг анхаарах хэрэгтэй ба мэдээллийн нэгдсэн байдлыг хадгалах хэрэгтэй. Учир нь нийт ой бүхий газар нутгийн мэдээлэл нь ГЗБГЗЗГ-ын мэдээлэл харин өөрчлөлтийн талаарх мэдээлэл нь ОСХТ-ийн мэдээлэл байж болзошгүй.
- ҮСХ-ны ашигладаг зэрлэг ан амьтан, байгалийн маягтанд ихэнхдээ зэрлэг амьтын ан агнуур тусгагдсан байдаг. Аймгууд жил бүр мэдээллээ бүрэн ирүүлдэггүй ба БОАЖЯ шалгадаггүй учир ҮСХ тэдгээр мэдээллийг нийтэлдэггүй. БОАЖЯ тус үйл явц ба маягтуудыг одоо эргэн харж байна. ҮСХ-нд зэрлэг ан амьтан, байгалийг хамгаалах хөрөнгө оруулалт зэрэг мэдээлэл шаардлагатай.
- СНСМС-д тохиромжтой бус мэдээллийн хувьд яам мэдээллээ тогтмол шалгадаггүй. Яамны дотоод аудитын газраар дамжсан тохиолдолд ашиглаж болно.

**Байгууллага хоорондын зохицуулалт ба СНСМС-ийн бүтэц**

Оролцогчид мөн СНСМС-ийн санал болгосон байгууллага хоорондын зохицуулалтыг авч хэлэлцсэн ба байгууллагуудын үүргийг харуулсан бүдүүвч зургийг шинэчлэв:




Хэлэлцүүлгээр дараах сэдвүүдийг голчлон авч хэлэлцэв:

- Мэдээллийн хэрэгцээ ба үзүүлэлтийг бүдүүвчинд оруулж болох уу? Болохгүй, хэтэрхий дэлгэрэнгүй болно.
- БОМТ нь өгөгдлийг эмхэтгэх чиг үүрэггүй, харин өгөгдлийн аюулгүй байдлыг хангах үүднээс зөвхөн техникийн шийдлийг хариуцах байгууллагуудаас ирүүлсэн мэдээ системд орж, систем өөрөө эмхэтгэдэг.
- ҮСХ өгөгдлийн чанар, бодит байдлыг шалгахад үүрэг гүйцэтгэх ёстой ба яг одоогийн байдлаар газрын сангийн тайлангийн мэдээг шалгах үүрэгтэй байна. Гэхдээ тэд ОСХТ-ийн өгөгдлийг БОМТ-ын ойн мэдээллийн санд ордог тул шалгадаггүй.
- СНСМС-ээс гарах мэдээлэлд тавих шаардлага, орох мэдээллийг тодруулах шаардлагатай. REDD+-ийнхяналт шалгалтын тайланг хэн бэлтгэх вэ? СНСМС нь өргөн хүрээний тайлан (Хяналт шалгалт, мэдээллийн хураангуй, байгаль орчны төлөв байдлын тайлан) бэлтгэх оролтууд үүсгэж болох боловч хэн нэгэн нь тайлангуудыг шинжиж, бэлтгэх шаардлагатай. Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн удирдлагын газар байгаль орчны төлөв байдлын тайланг хариуцдаг. ОБЗГ нь REDD+ явц болон СНЗ-ын мэдээллийг бэлтгэж илгээнэ.
- Баталгаажуулах үүргийг бас тодруулах шаардлагатай. Бүрэлдэхүүн хэсгүүдийг нь баталгаажуулдаггүй тул СНМС-ийн өгөдлийг баталгаажуулах магадлал бага. Байгаль орчны төлөв байдлын тайланг оролцогч талууд мөн баталгаажуулдаггүй. SOI тайланг баталгаажуулах явцыг тодорхойлох шаардлагатай.
- Олон нийт, ИНБ-уудын санал сэтгэгдлийг шинжилгээ хийх үед буюу эрт тусгах шаардлагатайг санал болгох, өөрөөр хэлбэл хариуцлагатай байгууллагууд СНМС-д бүрдүүлдэг өөрсдийн мэдээллээ хянахад иргэний нийгмийг татан оролцуулж болно. Гэхдээ энэ тийм түгээмэл явдал биш (?)
- ҮСХ-ны зүгээс тоон үзүүлэлттэй, албан ёсны мэдээллийг илгээснээс хойш өөрчлөх боломжгүйг тэмдэглэсэн.

Хурлын дараагийн хэсэгт СНСМС—ийн бүтэц болон СНСМС-д нэгдсэн эсвэл бие даасан барилын аль нь илүү тохиромжтойг хэлэлцсэн. Нэгдсэн системийн арга нь мэдээллийн сангуудыг онлайнаар, автоматаар нэгтгэн СНСМС-д холбогдолтой мэдээллийг гаргаж авах замаар ажиллана. Харин бие даасан системийн аргыг Монголд мэдээллийн сангуудад түгээмэл ашигладаг ба мэдээллийг маягтаар дамжуулан цуглуулах эсвэл агентлагууд мэдээллийн сан руу мэдээллээ өөрсдөө оруулдаг. Оролцогчид хоёр бүлэгт хуваагдан бүлэг тус бүр дээрх хоёр аргын давуу болон сул талуудыг харуулсан бүдүүвч зураг бүтээв.

Бүлэг 1: Нэгдсэн системийн арга барил




Давуу тал

1. Албан ёсны мэдээллийн эх сурвалж ашиглаж болно
2. Автоматаар шинэчлэгддэг тул цаг, ажиллагаа хэмнэнэ
3. Шинэ мэдээлэл үүсгэж болно
4. Нарийвчилсан шинжилгээ хийж болно

Сул тал:

1. Өөр өөр эх сурвалжаас авсан тоо баримт статистик зөрүүтэй байж болзошгүй
2. Зарим хэрэгцээтэй мэдээлэл байхгүй, өөрөөр хэлбэл бусад эх сурвалжаас цуглуулах, нэгтгэх шаардлагатай

Шийдвэрлэх асуудал:

1. Албан ёсны аль мэдээлэл зорилгод хамгийн их нийцэж буйг тодорхойлох шаардлагатай
2. Загвар, хэрэглээ үүсгэх шаардлагатай
3. СНСМС-ийг ажиллуулахын тулд хариуцсан хүн шаардлагатай
4. Мэдээллийн дүн шинжилгээг шалгаж баталгаажуулах шаардлагатай

Бүлэг 2:  Бие даасан системийн арга  барил




Давуу талууд:

1. Өгөгдлийн чанар болон агуулга сайжирна
2. Системийг ажиллуулахад бусад байгууллагаас бага хамааралтай
3. Мэдээлэл болон тайланг боловсруулахад илүү хялбар
4. Мэдээллийн санг шинэчлэн боловсруулах боломж ихтэй
5. Өгөгдлийг засч, залруулж болно

Сул талууд:

- Цаг их авдаг
- Бичиг цаасны ажил нэмэгдэнэ

**СНСМС-ийг ажиллуулахад шаардагдах зүйлс**

Хуралдааны сүүлчийн хэлэлцүүлгээр СНСМС-ийг ажиллуухад шаардагдах зүйлсийн талаар авч үзэв. Оролцогчид гурван бүлэгт хуваагдан боловсон хүчний хэрэгцээ, бодлого ба байгууллагын хэрэгцээ мөн техник, тоног төхөөрөмжийн хэрэгцээний талаар хэлэлцэж ажиллалаа:

| **СНСМС-ийн мэдээллийн сан болон вэбсайтыг ажиллуулахад шаардлагатай боловсон хүчний нөөц?** | **Боловсон хүчний нөөцийн талаар дэлгэрэнгүй: Хэдэн хүн хэрэгтэй вэ?** |
|---|---|
| Мэдээллийг зохион байгуулалтад оруулах | • Мэдээлэл цуглуулах<br>• Өгөгдлийг эмхэтгэх, нэгтгэх |
| • Сервер, техникийн ажилтан | • БОМТ-ийн серверын ажилтан системд хяналт тавина |
| • Тайлан боловсруулах<br>• Тайлан гаргах – БОАЖЯ-ны ОБЗГ | • БОАЖЯ (одоо байгаа БОМТ-ийн эрх үүргээс гадна) |
| 1 ажилтны төсөв at БОМТ | 700,000 төгрөг*12 сар |
| **СНСМС-ийн ба СНСЗ-уудын үйл ажиллагаа хэрэгжилтийн чадавхыг сайжруулахын тулд ямар чадавх бэхжүүлэх сургалт шаардлагатай вэ?** | **Үйл ажиллагааны дэлгэрэнгүй** |
| • Холбогдох байгууллагын ажилтнуудыг жилд нэг удаа сургалтанд хамруулах (гадаадаас сургагч багш авчрах уу?) | • БОАЖЯ ба БОМТ хамтран сургалт явуулна.<br>• ҮСХ, ГЗБГЗЗГ, ОСХТ, БОМТ, ОБЗГ, ОБЕГ ба ЦЕГ зэрэг байгууллагын 10 ажилтныг 1 өдрийн сургалтанд хамруулах (ОБЗГ ба БОМТ,) сургагч багшийн зардал, танхим, үдийн хоол |
| • 21 аймгийн байгаль орчны мэдээллийн сангийн ажилтнуудыг жилд нэг удаа мэдээллээр хангах. | • БОМТ ба ГЗБГЗЗГ-ын 22 ажилтныг сургалтанд хамруулах (орон нутгаас оролцогчдод томилолтын зардал, сургагч багшийн зардал, танхим, тараах материал, үдийн хоол) |
| **Бусад үйл ажиллагаанд оролцох боловсон хүчний нөөц?** | **Аль байгууллагын мэргэжилтнүүд байх вэ?** |
| • Мэдээ, өгөгдлийн чанарыг үнэлж баталгаажуулах г.м. | • Байгууллага бүрийн мэргэжилтэн нь бүрдүүлсэн өгөгдлийг хянаж шалган БОМТ-ыг удирдамжаар хангах үүрэгтэй |

| | |
|---|---|
| • Мониторингийн үйл ажиллагаа явуулах | • Холбогдох байгууллагууд болон ТББ-ууд мониторинг явуулж болно |
| • Тайлан боловсруулах | • БОАЖЯ-ны ОБЗГ, УАӨГХАГ-ын мэргэжилтнүүд ба УАӨТХН-ийн мэргэжилтэн<br>• БОМТ-ийн мэргэжилтэн |
| • Тайлан батлуулах | • БОАЖЯ-ны ОБЗГ, УАӨГХАГ, УАӨТХН ба БОМТ (хурлын зардал) |
| • МХ тайланг НҮБ-ын УАӨСК-д илгээх | • БОАЖЯ-ны УАӨГХАГ ба УАӨТХН |
| **СНМС-ийг ажиллуулах улс төрийн болон менежментийн хэрэгцээ** | |
| • Байгууллагуудын чиг үүрэгт нэмж оруулах<br>• Мэдээлэл солилцох гэрээ байгуулах<br>• Заавар ба журам<br>• Вэб хуудасны зөвшөөрөл<br>• Шаардлагатай бусад зөвшөөрөл:<br>  ○ СНСМС-ийг ажиллуулах заавар<br>  ○ Байгууллага хооронд мэдээлэл солилцох Харилцан ойлголцлын санамж бичиг боловсруулах<br>  ○ Байгууллага хоорондын өгөгдлийн зөрүүг арилгах | Заавар:<br>○ Байгууллагуудын мандат<br>○ Мэдээлэл эмхэтгэх цаг хугацаа<br>○ Мэдээлэл цуглуулах, тайлан боловсруулах ба маягтууд хавсаргах<br>○ Мэдээлэл солилцоо<br>Харилцан ойлголцлын санамж бичиг:<br>○ Мэдээлэл бэлтгэж солилцох тухай<br>○ Үүрэг хариуцлагыг заах<br>○ Давуу эрх эсвэл нэмэлт бололцоог харуулах (сургалт, техникийн дэмжлэг ба технологийн сургалт) |
| **Тайлан боловсруулж батлуулах ажлыг хэн хариуцах вэ?** | |
| БОАЖЯ-ны ОБЗГ | |
| **СНСМС-ийг ажиллуулахад шаардлагатай мэргэжилтэн, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл** | |
| 1. Програм хангамж зохиогч<br>2. Компьютер ба принтер<br>3. Програм хангамжийн загвар<br>4. Оролцогч талууд<br>5. Өрөө | 1. Сервер<br>2. Толгой компьютер<br>3. 1 мэргэжилтэн |

| Тайлбар: | Тайлбар: |
|---|---|
| 1. IT инженер- 2 хүн*3 сар*1 сая=6 сая төгрөг<br>2. Персонал компьютер-2ш*2сая=4 сая төгрөг<br>3. Принтер 1 ширхэг- 500.0 мянган төгрөг<br>4. Захиргааны зардал (харилцаа холбоо ба бичиг хэрэг) 3 сар*1 сая=3 сая төгрөг<br>5. Хэлэлцүүлгийн зардал-1 сая төгрөг<br>6. Өрөө (30-40m$^2$) 3 сар*200.0=600.0 мянган төгрөг | 1. Сервер- 30 сая төгрөг<br>2. Толгой компьютер - 5 сая төгрөг<br>3. 1 мэргэжилтний цалин 12 сар*600.0 мянган төгрөг = 7.2 сая төгрөг<br><br>Нийт 42.2 сая төгрөг<br><br>Хөргөгч сэнс, UPS (тог баригч) |




UN-REDD PROGRAMME

Food and Agriculture Organization of the United Nations

UN environment

*Монгол орны UN-REDD Үндэсний Хөтөлбөр*
*Хаяг: Засгийн газрын II байр, Нэгдсэн үндэстний гудамж 5/2, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар 15160, Монгол улс*
*Утас: +976-7711-7750*
*Цахим шуудан: info@unredd.mn*
*Вэбсайт: www.reddplus.mn*